



**ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН
ХОРОО**



**ЭРҮҮЛ МЭНДИЙН
ХӨГЖЛИЙН ТӨВ**

УЛААНБААТАР ХОТЫН АГААРЫН БОХИРДЛЫН ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

**УЛААНБААТАР ХОТ
2020 ОН**

Судалгааны тайланг хянасан:

А.Ариунзаяа
Үндэсний статистикийн хорооны дарга

Ч.Баянчимэг
Үндэсний статистикийн хорооны дарга

Судалгааны тайланг бичсэн:

Г.Урангоо
Үндэсний Статистикийн хорооны Хүн ам, нийгмийн статистикийн газрын статистикч

Х.Нарантуяа
Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эрүүл мэндийн мэдээллийн албаны мэргэжилтэн

АГУУЛГА

АГУУЛГА.....	3
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР.....	4
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	5
ХҮН АМЫН ӨСӨЛТ	9
АГААРЫН БОХИРДОЛ.....	13
ХҮН АМЫН ӨВЧЛӨЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ.....	26
Амьсгалын тогтолцооны өвчлөл.....	28
Нөхөн үржихүйн тогтолцооны өвчлөл.....	37
Зүрх судасны тогтолцооны өвчлөл.....	42
ДҮГНЭЛТ	45
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	49

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НҮЭМ	Нөхөн үржихүйн эрүүл мэнд
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
УИХ	Улсын Их Хурал
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ЗГ	Засгийн газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ҮАБЗ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
ЭМХТ	Эрүүл мэндийн хөгжлийн төв
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ХДХВ/ДОХ	Хүний дархлал, хомсдолын вирус/ Дархлалын олдмол хомсдол
ЭМД	Эрүүл мэндийн даатгал

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 1. ОРОН НУТГААС УЛААНБААТАР ХОТОД ШИЛЖИН ИРСЭН ХҮНИЙ ТОО, МЯНГАН ХҮНЭЭР, 1990-2019 ОН	9
ЗУРАГ 2. ӨРХИЙН ТОО, 2010-2019 ОН	10
ЗУРАГ 3. УЛААНБААТАР ХОТЫН ГАЛЛАГААТ ХАЛААЛТТАЙ ӨРХИЙН ХУВЬ, (ЕРДИЙН ГАЛЛАГАА, НАМ ДАРАЛТЫН ЗУУХ АШИГЛАДАГ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ)	10
ЗУРАГ 4. УЛААНБААТАР ХОТЫН ӨРХИЙН НҮҮРСНИЙ ХЭРЭГЛЭЭ, МЯНГАН ТОНН, 2010-2019	11
ЗУРАГ 5. БҮРТГЭЛТЭЙ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТОО, МЯНГАН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ, 2012-2019 ОН	11
ЗУРАГ 6. БҮРТГЭЛТЭЙ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН НАСЖИЛТ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2012-2019 ОН.....	12
ЗУРАГ 7. ТООСОНЦРЫН ХЭМЖЭЭНИЙ ХАРЬЦУУЛАЛТ	13
ЗУРАГ 8. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ 2.5 МИКРОНООС БАГА ХЭМЖЭЭТЭЙ ТООСНЫ 2011-2019 ОНЫ ХАРГАЛЗАХ САРУУДЫН ДУНДАЖ, ХАМГИЙН ИХ, ХҮЛЦЭХ АГУУЛАМЖ (МГ/М ³)	14
ЗУРАГ 9. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ 2.5 МИКРОНООС БАГА ХЭМЖЭЭТЭЙ ТООСНЫ.....	15
ЗУРАГ 10. УБ ХОТЫН АГААР ДАХЬ 2.5 МИКРОНООС БАГА ХЭМЖЭЭТЭЙ ТООСНЫ ХАМГИЙН ИХ, ХҮЛЦЭХ АГУУЛАМЖ (МГ/М ³), 2019, 2020 ОНЫ САРААР	15
ЗУРАГ 11. УБ ХОТЫН АГААР ДАХЬ 2.5 МИКРОНООС БАГА ХЭМЖЭЭТЭЙ ТООСНЫ ДУНДАЖ АГУУЛАМЖ (МГ/М ³), 2019, 2020 ОНЫ САР БҮРЭЭР	16
ЗУРАГ 12. УБ ХОТЫН АГААР ДАХЬ 2.5 МИКРОНООС БАГА ХЭМЖЭЭТЭЙ ТООСНЫ САРЫН ДУНДАЖ АГУУЛАМЖ (МГ/М ³), ЖИЛ БҮРИЙН ЭХНИЙ 3 САРЫН ДУНДЖААР, БАЙРШЛААР	16
ЗУРАГ 13. РМ10 ТООСОНЦРЫН АГУУЛАМЖ, 2010-2019 ОНЫ ХАРГАЛЗАХ САРУУДЫН ДУНДАЖ, ХАМГИЙН ИХ, ХҮЛЦЭХ АГУУЛАМЖ, МГ/М ³	17
ЗУРАГ 14. РМ10 ТООСОНЦРЫН АГУУЛАМЖ, 2010-2019 ОНЫ ЖИЛИЙН ДУНДАЖ, ХАМГИЙН ИХ, ХҮЛЦЭХ АГУУЛАМЖ (МГ/М ³)	17
ЗУРАГ 15. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ 10 МИКРОНООС БАГА ХЭМЖЭЭТЭЙ ТООСНЫ ХАМГИЙН ИХ АГУУЛАМЖ (МГ/М ³), 2019, 2020 ОНЫ САРААР	18
ЗУРАГ 16. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ 10 МИКРОНООС БАГА ХЭМЖЭЭТЭЙ ТООСНЫ ДУНДАЖ АГУУЛАМЖ (МГ/М ³), 2019, 2020 ОНЫ САРААР	18
ЗУРАГ 17. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ 10 МИКРОНООС БАГА ХЭМЖЭЭТЭЙ ТООСНЫ САРЫН ДУНДАЖ АГУУЛАМЖ (МГ/М ³), ЖИЛ БҮРИЙН ЭХНИЙ 3 САРЫН ДУНДЖААР, БАЙРШЛААР	19
ЗУРАГ 18. ТООСОНЦРУУДЫН 2011-2019 ОНЫ ХАРГАЛЗАХ САРУУДЫН ДУНДЖААР, ХҮЛЦЭХ АГУУЛАМЖААС ДАВСАН ХУВЬ.....	19
ЗУРАГ 19. ТООСОНЦРУУДЫН ХҮЛЦЭХ АГУУЛАМЖААС ДАВСАН ХУВЬ, ЖИЛ БҮРИЙН ЭХНИЙ 3 САРЫН БАЙДЛААР.....	20
ЗУРАГ 20. ХҮХЭРЛЭГ ХИЙН 2010-2019 ОНЫ ХАРГАЛЗАХ САРУУДЫН ДУНДАЖ АГУУЛАМЖ, МГ/М ³	20
ЗУРАГ 21. ХҮХЭРЛЭГ ХИЙН (SO ₂) 2010-2019 ОНЫ ЖИЛИЙН ДУНДАЖ, ХАМГИЙН ИХ, ХҮЛЦЭХ АГУУЛАМЖ (МГ/М ³)	21
ЗУРАГ 22. ХҮХЭРЛЭГ ХИЙН (SO ₂) ХАМГИЙН ИХ, ХҮЛЦЭХ АГУУЛАМЖ (МГ/М ³), 2019, 2020 ОНЫ САРААР	21
ЗУРАГ 23. ХҮХЭРЛЭГ ХИЙН САРЫН ДУНДАЖ АГУУЛАМЖ (МГ/М ³), ЖИЛ БҮРИЙН ЭХНИЙ 3 САРЫН ДУНДЖААР, БАЙРШЛААР,	22
ЗУРАГ 24. ХҮХЭРЛЭГ ХИЙ, АЗОТЫН ДАВХАР ИСЛИЙН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ХЭМЖЭЭНЭЭС ДАВСАН ХУВЬ, 2011-2019 ОН.....	22
ЗУРАГ 25. АЗОТЫН ДАВХАР ИСЛИЙН 2010-2019 ОНЫ ХАРГАЛЗАХ САРУУДЫН ДУНДАЖ АГУУЛАМЖ (МГ/М ³)	23
ЗУРАГ 26. АЗОТЫН ДАВХАР ИСЛИЙН (NO ₂) 2010-2019 ОНЫ ЖИЛИЙН ДУНДАЖ, ХАМГИЙН ИХ, ХҮЛЦЭХ АГУУЛАМЖ (МГ/М ³)	23
ЗУРАГ 27. АЗОТЫН ДАВХАР ИСЛИЙН (NO ₂) ХАМГИЙН ИХ, ХҮЛЦЭХ АГУУЛАМЖ (МГ/М ³), 2019, 2020 ОНЫ САРААР	24
ЗУРАГ 28. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ АЗОТЫН ДАВХАР ИСЛИЙН САРЫН ДУНДАЖ АГУУЛАМЖ (МГ/М ³), ЖИЛ БҮРИЙН ЭХНИЙ 3 САРЫН ДУНДЖААР, БАЙРШЛААР	25
ЗУРАГ 29. ХҮХЭРЛЭГ ХИЙ, АЗОТЫН ДАВХАР ИСЛИЙН ХҮЛЦЭХ АГУУЛАМЖИЙН ДАВСАН ХУВЬ,	25
ЗУРАГ 30. АМБУЛАТОРИЙН ӨВЧЛӨЛИЙН ТОХИОЛДОЛ, МЯНГАН ХҮН	26
ЗУРАГ 31. АМБУЛАТОРИЙН ӨВЧЛӨЛИЙН ТОХИОЛДОЛ, БАЙРШЛААР.....	27
ЗУРАГ 32. АГААРЫН БОХИРДЛЫН ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД ҮЗҮҮЛЭХ ХОР, НӨЛӨӨ	28
ЗУРАГ 33. АМЬСГАЛЫН ТОГТОЛЦООНЫ ӨВЧЛӨЛ, 10000 ХҮН АМД НОГДОХООР, 2010-2019 ОН	28
ЗУРАГ 34. АМБУЛАТОРИД БҮРТГЭГДСЭН НИЙТ ӨВЧЛӨЛ, АМЬСГАЛЫН ТОГТОЛЦООНЫ ӨВЧЛӨЛ,	29

ЗУРАГ 35. ЭМД-ЫН САНГААС ХӨНГӨЛӨЛТӨӨР ОЛГОДОГ ХҮҮХДИЙН ЭМИЙН БОРЛУУЛАЛТ, САЯ ТӨГРӨГ, ЖИЛ БҮРИЙН ЭХНИЙ ЗАРДАЛ САЯ ТӨГРӨГ, 2018-2019 ОН.....	ЗУРАГ 36. УБ ХОТЫН 0-17 НАСНЫ ЭМЧИЛГЭЭНИЙ	29
ЗУРАГ 37. УЛААНБААТАР ХОТЫН 0-17 НАСНЫ ХҮҮХДИЙН АМЬСГАЛЫН ТОГТОЛЦООНЫ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ, ЗАРЦУУЛСАН ЭМЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ, ЖИЛ БҮРИЙН ЭХНИЙ 3 САРЫН БАЙДЛААР ...		30
ЗУРАГ 38. УЛААНБААТАР ХОТЫН 0-17 НАСНЫ ХҮҮХДИЙН АМЬСГАЛЫН ТОГТОЛЦООНЫ ӨВЧНӨӨР ЭМНЭЛЭГТ ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛСЭН ТОХИОЛДОЛ, БАЙРШЛААР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2018-2019 ОН		30
ЗУРАГ 39. УЛААНБААТАР ХОТЫН ХҮН АМЫН АМЬСГАЛЫН ТОГТОЛЦООНЫ ӨВЧИН, ЗАРИМ ӨВЧИН, 10000 ХҮН АМД НОГДОХООР, 2010-2019 ОН		31
ЗУРАГ 40. УЛААНБААТАР ХОТЫН ХҮН АМЫН АМЬСГАЛЫН ТОГТОЛЦООНЫ ЗАРИМ ӨВЧИН, 10000 ХҮНД НОГДОХООР, 2015-2019 ОНЫ ХАРГАЛЗАХ САРУУДЫН ДУНДЖААР		31
ЗУРАГ 41. УЛААНБААТАР ХОТЫН ХАТГАЛГАА ӨВЧНИЙ ТҮВШИН, 10000 ХҮНД НОГДОХООР, 2018-2019 ОН, САРААР		32
ЗУРАГ 42. УЛААНБААТАР ХОТЫН ХАТГАЛГАА, ЦОЧМОГ БРОНХИТ ӨВЧНИЙ ТҮВШИН, 10000 ХҮНД НОГДОХООР, ЖИЛ БҮРИЙН ЭХНИЙ 3 САРЫН БАЙДЛААР		32
ЗУРАГ 43. АМЬСГАЛЫН ТОГТОЛЦООНЫ ЗАРИМ ӨВЧИН, НАСНЫ БҮЛГЭЭР, 10 000 ХҮН АМД НОГДОХООР, 2019 ОН		33
ЗУРАГ 44. УЛААНБААТАР ХОТЫН 5 ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН АМЬСГАЛЫН БОЛОН ХАТГАЛГАА ӨВЧНИЙ ТҮВШИН, 10000 ХҮҮХДЭД НОГДОХООР, 2010-2019 ОН		34
ЗУРАГ 45. УЛААНБААТАР ХОТЫН ХАТГАЛГАА ӨВЧНӨӨР НАС БАРСАН НИЙТ ХҮН АМ, 5 ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХЭД, (10000 ХҮН АМД НОГДОХ) 2010-2019 ОН		34
ЗУРАГ 46. ТАВ ХҮРТЭЛХ НАСНЫ 1000 ХҮҮХДЭД НОГДОХ ХАТГАЛГАА ӨВЧИН, САРААР, 2015-2019 ОН ...		35
ЗУРАГ 47. ТАВ ХҮРТЭЛХ НАСНЫ 1000 ХҮҮХДЭД НОГДОХ ХАТГАЛГАА ӨВЧНИЙ ТҮВШИН, ЖИЛ БҮРИЙН ЭХНИЙ 3 САРЫН БАЙДЛААР		35
ЗУРАГ 48. УЛААНБААТАР ХОТЫН 10 000 ХҮН АМД НОГДОХ УУШГИНЫ АРХАГ БӨГЛӨРӨЛ ӨВЧИН, САРААР, 2015-2019 ОН		36
ЗУРАГ 49. УЛААНБААТАР ХОТЫН 10000 ХҮН АМД НОГДОХ УУШГИНЫ АРХАГ БӨГЛӨРӨЛ ӨВЧИН, ЖИЛ БҮРИЙН ЭХНИЙ 3 САРЫН БАЙДЛААР		36
ЗУРАГ 50. УЛААНБААТАР ХОТЫН 10000 ХҮН АМД НОГДОХ УУШГИНЫ ХАВДАР, САРААР, 2015-2019 ОН .		37
ЗУРАГ 51. УЛААНБААТАР ХОТЫН 10000 ХҮН АМД НОГДОХ УУШГИНЫ ХАВДАР, САРААР, 2015-2019 ОН .		37
ЗУРАГ 52. УЛААНБААТАР ХОТЫН 1000 АМЬД ТӨРӨЛТӨД НОГДОХ ДУТУУ ТӨРӨЛТ, ТӨРӨЛХИЙН ГАЖИГТАЙ ХҮҮХЭД, АМЬГҮЙ ТӨРӨЛТ, 2015-2019 ОН, 2020 ОНЫ ЭХНИЙ 3 САРЫН БАЙДЛААР		38
ЗУРАГ 53. УЛААНБААТАР ХОТЫН 1000 АМЬД ТӨРӨЛТӨД НОГДОХ ТӨРӨЛХИЙН ГАЖИГТАЙ ТӨРСӨН ХҮҮХЭД, АМЬГҮЙ ТӨРӨЛТИЙН ТҮВШИН, САРААР, 2015-2019		38
ЗУРАГ 54. УЛААНБААТАР ХОТЫН 1000 АМЬД ТӨРӨЛТӨД НОГДОХ ТӨРӨЛХИЙН ГАЖИГТАЙ ТӨРСӨН ХҮҮХЭД, АМЬГҮЙ ТӨРӨЛТИЙН ТҮВШИН, ЖИЛ БҮРИЙН ЭХНИЙ 3 САРЫН БАЙДЛААР		39
ЗУРАГ 55. УЛААНБААТАР ХОТЫН 1000 АМЬД ТӨРӨЛТӨД НОГДОХ ДУТУУ ТӨРӨЛТИЙН ТҮВШИН, САРААР, 2015-2019 ОН.....		39
ЗУРАГ 56. УЛААНБААТАР ХОТЫН 1000 АМЬД ТӨРӨЛТӨД НОГДОХ ДУТУУ ТӨРӨЛТИЙН ТҮВШИН, ЖИЛ БҮРИЙН ЭХНИЙ 3 САРЫН БАЙДЛААР		40
ЗУРАГ 57. 1000 АМЬД ТӨРӨЛТӨД НОГДОХ ӨСӨЛТГҮЙ ЖИРЭМСЛЭЛТ, 2015-2019 ОН.....		40
ЗУРАГ 58. УЛААНБААТАР ХОТЫН 1000 АМЬД ТӨРӨЛТӨД НОГДОХ ӨСӨЛТГҮЙ ЖИРЭМСЛЭЛТ, САРААР, 2015-2019 ОН		41
ЗУРАГ 59. УЛААНБААТАР ХОТЫН 1000 АМЬД ТӨРӨЛТӨД НОГДОХ ӨСӨЛТГҮЙ ЖИРЭМСЛЭЛТ, ЖИЛ БҮРИЙН ЭХНИЙ 3 САРЫН БАЙДЛААР		41
ЗУРАГ 60. УЛААНБААТАР ХОТЫН 10 000 ХҮН АМД НОГДОХ ЗҮРХ, СУДАСНЫ ТОГТОЛЦООНЫ ЗАРИМ ӨВЧИН, 2010-2019		42
ЗУРАГ 61. УЛААНБААТАР ХОТЫН 10000 ХҮН АМД НОГДОХ АНХДАГЧ ДАРАЛТ ИХСЭХ ӨВЧИН, САРААР, 2015-2019 ОН.....		43
ЗУРАГ 62. УЛААНБААТАР ХОТЫН 10000 ХҮН АМД НОГДОХ АНХДАГЧ ДАРАЛТ ИХСЭХ ӨВЧИН, ЭХНИЙ 1-3 САРААР, 2015-2019 ОН		43
ЗУРАГ 63. УЛААНБААТАР ХОТЫН 10000 ХҮН АМД НОГДОХ ЗҮРХНИЙ ШИГДЭЭС ӨВЧИН, САРААР, 2015-2019 ОН		44
ЗУРАГ 64. УЛААНБААТАР ХОТЫН 10000 ХҮН АМД НОГДОХ ЗҮРХНИЙ ШИГДЭЭС ӨВЧИН, ЖИЛ БҮРИЙН ЭХНИЙ 3 САРЫН БАЙДЛААР		44

УДИРТГАЛ

Хүний эрүүл мэндэд түүний амьдралын дадал зуршил, хоол хүнс, хүрээлэн буй орчин зэрэг олон хүчин зүйл нөлөөлдөг.

Олон судалгаагаар хүрээлэн буй орчноос агаарын бохирдол нь хүний эрүүл мэндийн байдалд нөлөөлдөг болохыг нотолсон юм. Их хэмжээний агаарын бохирдолтой орчинд амьдрах нь хүн амын ялангуяа хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг.

НҮБ, ДЭМБ-аас дэлхий дээрх 10 хүний 9 нь бохирдсон агаараар амьсгалж, жил бүр 7 сая, цаг тутамд 800 хүн, минут тутамд 13 хүн нас бардаг гэсэн тооцоолол гарсан. Энэ нь сүрьеэ, ХДХВ, ДОХ, хумхаа өвчнөөр нас барсан нийт хүнээс 3 дахин их байна. Уушгины үрэвсэл, бронхит, амьсгалын замын архаг өвчлөл гээд агаарын бохирдолтой холбогдох олон өвчнийг энд нэрлэж болно. Хүүхэд өсөж том болсон хойно ч тэдний уушгины үйл ажиллагааг сулруулах гэх мэтээр хүндрэл үүсгэж болзошгүй байдаг. Уушгины архаг бөглөрөл өвчнөөр нас барсан 4 хүний 1, уушгины хавдраар нас барсан 5 хүний 1, тархины цус харвалтаар нас барсан 10 хүний 1, зүрхний ишемийн өвчнөөр нас барсан 10 хүний 1 нь агаарын бохирдолтой холбоотой байна. Дэлхийн хэмжээнд 2016 оны байдлаар хүүхдүүдийн 93 хувь нь агаарын бохирдол ихтэй бүс нутаг амьдарч байгаагаас 15 хүртэлх насны 600.0 мянган хүүхэд нь амьсгалын замын халдвараас болж нас баржээ. АНУ-ын Эрүүл мэндийн хүрээлэнгийн хийсэн судалгаагаар агаарын бохирдол нь төрсөн хүүхдийн дундаж наслалтыг 20 сараар богиносгож байгаа тухай дурджээ. Агаарын бохирдол төрөөгүй хүүхдэд хүртэл сөргөөр нөлөөлж жин багатай, дутуу тээлттэй, амьгүй төрөх зэрэг ноцтой үр дагавар үүсгэдэг. Жирэмсэн байх үед болон төрсний дараах эхэн үед хүүхдийн тархины болон танин мэдэхүйн хөгжилд агаарын бохирдол сөрөг нөлөөтэй болохыг сүүлийн үеийн судалгааны баримтууд харуулж байна. Дэлхийн 100,000-аас дээш хүн амтай, бага, дунд орлоготой орнуудын 97% нь, өндөр орлоготой орнуудын 29% нь агаарын бохирдолтой хотууд байна. Дэлхийн хотуудын агаарын бохирдлын 25 орчим хувь нь тоосонцор, 20 хувь нь өрхийн хэрэглээнээс үүссэн утаа, 15 хувь нь цахилгаан станц болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас үүсдэг байна. Дэлхийн 7 тэрбум гаруй хүнээс 3 тэрбум орчим нь агаарыг бохирдуулагч керосин, түүхий нүүрс, хатуу түлшийг энгийн зууханд болон ил задгай түлж хоол удаа болгохдоо ашиглаж байна. Өрхийн агаарын бохирдлын улмаас дэлхий дээр жилд 3.8 сая хүн зуурдаар нас бардаг бөгөөд үүний 27% нь уушгины хатгалгаа, 27% нь зүрхний ишемийн өвчин, 18% нь уушгины архаг бөглөрөлт өвчин, 20% нь тархины цус харвалт, 8% нь уушгины хорт хавдрын шалтгаант нас баралт байна. Мөн 5 хүртэлх насны хүүхдүүдийн уушгины хатгалгаа өвчний улмаас нас баралтын тал орчим хувь нь ахуйн агаарын бохирдлоос үүсдэг байна. Парисын 2015 оны хэлэлцээрийн үеэр Засгийн газрууд 2050 он гэхэд дэлхийн дулаарлыг цельсийн 2 хэмээс бага болгон, агаарын бохирдлыг бууруулах замаар жилд сая орчим хүний амийг аврах боломжтой гэжээ. Үүний тулд дэлхийн дулаарлыг хамгийн их бий болгож буй 15 орны агаарын бохирдлыг бууруулах зардлыг ДНБ-ний 4 хувиас дээш, дэлхийн ДНБ-ний 1 хувь орчим байхаар шаардах болно хэмээн анхааруулсан¹.

Эрс тэс уур амьсгалтай манай орны өвлийн хүйтэн улиралд гэр, байшинд амьдардаг иргэдийн боловсруулаагүй нүүрсний хэрэглээ өндөр байдаг. Нүүрсний хэрэглээ нь хүн ам багатай суурин газруудад төдийлөн асуудал болдоггүй бол шилжих хөдөлгөөнөөс шалтгаалан хүн амын төвлөрөл нэмэгдсэн Улаанбаатар хот, зарим аймгийн төв суурин газарт агаарын бохирдол аюултай хэмжээнд хүрч байна.

¹ <https://www.weforum.org/agenda/2019/06/10-facts-about-air-pollution-on-world-environment-day>

Сүүлийн гучин жилд Улаанбаатар хотын хүн ам хурдацтай өсөж 1 км² газар нутагт 1989 онд 169 хүн ногдож байсан бол 2018 онд нийт хүн амын 45.3 буюу 1.4 сая хүн амьдарч, 1 км² газар нутаг 311 хүн ногдож 1989 оноос 1.8 дахин нэмэгджээ.

Монгол Улсын хэмжээнд 2018 оны байдлаар нийт өрхийн 72.0 хувь нь, Улаанбаатар хотын нийт өрхийн 53.9 хувь нь түүхий нүүрс түлж гэрээ халааж байна.

Улаанбаатар хотын агаарын бохирдлын 80 хувийг гэр хорооллын айл өрхийн гэрийн зуух болон аж ахуйн нэгж, байгууллагын 3200 орчим халаалтын зуух, 10 хувийг замын хөдөлгөөнд оролцож байгаа 400 мянга гаруй авто тээврийн хэрэгсэл, 5-6 хувийг дулааны цахилгаан станцууд, 4 хувийг үнсэн сан, замын тоос шороо, ил задгай хаясан хог хаягдал зэрэг бусад эх үүсвэр ялгаруулж байна².

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2-т заасан “Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж заасныг ханган, баталгаажуулах зорилгоор УИХ-аас анх 1995 онд “Агаарын тухай хууль”-ийг баталж, хамгийн сүүлд 2012 оны 5 дугаар сард шинэчлэн баталсан. Агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагааны хүрээнд 1992-2016 онд УИХ-аас 26, ҮАБЗ-өөс 2 эрх зүйн шийдвэр, ЗГ-аас 24 тогтоол гаргасан байна.

Үндэсний аудитын газрын 2018 оны гүйцэтгэлийн аудитын тайланд дотоодын болон олон улсын байгууллагын зээл, тусламж, санхүүжилтээр 2008-2016 онд агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагаанд нийт 490 гаруй тэрбум төгрөгийн санхүүжилт зарцуулсан нь ДНБ-ний 3.1 хувийг эзэлж байна.

Монгол Улсын Засгийн газар 2018 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 62 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн өрхийн хэрэглээнд 2019 оны 5-р сарын 15-ны өдрөөс эхлэн боловсруулаагүй нүүрсийг хэрэглэхийг хориглож, сайжруулсан нүүрсийг хэрэглэх болсон. Үүний үр дүнд агаарын бохирдлын хэмжээ 50 хүртэл хувиар буурна гэж үзжээ.

Манай улсад ковид-19 өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2020 оны эхнээс цэцэрлэг, сургууль, үйлчилгээний газруудын үйл ажиллагааг зогсоож, хөл хорио тогтоосон, хүн бүр амны хаалт зүүхийг шаардаж, хувийн болон амьдарч, ажиллах орчны ариун цэврийг эрс сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Энэ судалгаагаар агаарын болон орчны бохирдлыг бууруулахтай холбоотой дээрх төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааг хэрэгжүүлснээр агаарын бохирдлын байдал, агаар, орчны бохирдлоос шалтгаалсан өвчлөл, нас баралтын байдалд ямар хандлага, өөрчлөлт гарсныг судалсан болно.

² Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр (2017-2025)


ХҮН АМЫН ӨСӨЛТ

Улаанбаатар хотын агаарын бохирдол нэмэгдэхэд нөлөөлсөн гол хүчин зүйлсийн нэг нь хүн амын шилжилт хөдөлгөөнөөс үүссэн механик өсөлт юм.

Сүүлийн 30 жилд Улаанбаатар хотын хүн ам хурдацтай өсөж, улсын нийт хүн амын 46.1 хувь буюу 1.5 сая хүн амьдарч байна. Улаанбаатар хотын хүн амын өсөлт нь шилжих хөдөлгөөнөөс шууд хамааралтай юм.

Улаанбаатар хотын нэг км² газар нутагт 1989 онд 117 хүн ногдож байсан бол 2019 онд 317 хүн ногдож, даруй 2.5 дахин нэмэгджээ. Энэ тоо цаашид ч өсөх хандлагатай байна.

Зураг 1. Орон нутгаас Улаанбаатар хотод шилжин ирсэн хүний тоо, мянган хүнээр, 1990-2019 он



Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- www.1212.mn

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 1995 оны 19 дүгээр тогтоолоор “Нийслэл хотод шилжин суурьших, түр оршин суух, нийслэлээс шилжин явах тухай түр журам” баталж нийслэлд оршин суух хүсэлт гаргасан иргэд 1995 оны 11-р сарын 15-наас эхэлж нэг удаагийн төлбөр төлдөг болсон. Энэхүү тогтоол хэрэгжиж эхэлсэн эхний 2 жилд шилжих хөдөлгөөн өмнөх жилүүдээс буурсан хэдий ч 1998 оноос буцаад өссөн байна. Тус журмыг 2004 оны 2-р сарын 18-ны өдрийн 20 дугаар тогтоолоор “Иргэдийн шилжих хөдөлгөөнийг бүртгэх журам” гэж шинэчлэн баталсан бөгөөд энэ журам нь ямар нэг төлбөр хураамжгүй болсон байна. Журам батлагдсанаас хойш шилжих хөдөлгөөний бүртгэл хоёр дахин өссөн байна. Энэ өсөлт нь шилжин ирэгчдээс гадна, шилжих хөдөлгөөний бүртгэлээ хийлгээгүй амьдарч байсан иргэд бүртгэлээ идэвхтэй хийлгэх болсонтой мөн холбоотой байж болох юм.


Мөн 1999 оноос 2003 он хүртэл жил дараалан ган зудын нөхцөл байдал үүсэж, нийт дүнгээрээ 13 сая гаруй мал хорогдож, олон тооны өрх айл орлогын эх үүсвэргүй болсноос шалтгаалан 2002 оноос 2004 он хүртэл жилд дунджаар 35.7 мянган хүн Улаанбаатар хотод шилжин ирсэн байна.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн А/17 дугаар захирамжаар 2017 оны 1-р сарын 9-нөөс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах зайлшгүй шаардлагатай болон албан томилолтоор нийслэлд зургаан сараас дээш хугацаагаар ажиллах төрийн албан хаагч, түүний гэр бүл, Улаанбаатар хотод орон сууц худалдан авснаас бусад тохиолдолд хөдөө орон нутгаас нийслэлд ирэх шилжилт

хөдөлгөөнийг 2020 оны 01 дүгээр сарын 01 хүртэл түр зогсоосон юм. Ингэснээр шилжин ирэлт 2017 онд өмнөх оноос 2.4 дахин, 2018 онд өмнөх оноос 1.6 дахин буурсан ч 2019 онд 12.4 мянга болж, 1.9 дахин нэмэгдсэн байна.

Шилжин ирэгчид нэмэгдсэнтэй холбоотойгоор сүүлийн 10 жилийн дунджаар Улаанбаатар хотод Монгол Улсын нийт өрхийн 42.8 хувь нь оршин сууж байна. Өрхийн тоо 2019 онд 412.0 мянга болж, өмнөх оноос 24.5 мянга (6.3%)-аар нэмэгдсэн байна.


Зураг 2. Өрхийн тоо, 2010-2019 он



Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- www.1212.mn

Улаанбаатар хотын агаарын бохирдол нь гэр хорооллын утаа, авто тээврийн хэрэгслээс ялгарах утаа, тортог, гурван том дулааны цахилгаан станцын утаа, хөрсний бохирдол зэргээс үүсдэг. Эдгээрээс хамгийн их нөлөө үзүүлж байгаа нь гэр хорооллын утаа юм³. Улаанбаатар хотын хүн ам өсөхийн хэрээр гэр хороолол тэлж, галлагаат (ердийн галлагаа болон нам даралтын зуух ашигладаг өрх) халаалттай өрхийн тоо өссөөр байна. Улаанбаатар хотын галлагаат халаалттай өрхийн эзлэх хувийг авч үзэхэд дараах байдалтай байна.

Зураг 3. Улаанбаатар хотын галлагаат халаалттай өрхийн хувь, (ердийн галлагаа, нам даралтын зуух ашигладаг өрхийн эзлэх хувь)



2010-2019 он Улаанбаатар хотод Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр 302.2 мянган өрхийн 60 хувь буюу 181.4 мянга нь, 2015 онд 376.4 мянган өрхийн 57.2 хувь буюу 215.3 мянга нь галлагаат халаалттай байжээ. Энэ үзүүлэлт нь 2019 оны байдлаар 215 мянган өрх буюу нийт өрхийн 52.2 хувийг эзэлж, өмнөх оноос 1.6 пунктээр буурсан байна.


Эх үүсвэр: Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, ҮСХ

³ Зориг сан, Агаарын бохирдлын тухай товчхон, 2018 он

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны үр дүнд үндэслэсэн тооцооллоор 2019 оны байдлаар нэг өрх жилд дунджаар 3.5 тонн нүүрс хэрэглэж байгаа нь 2010 оноос 0.7 тонноор буурсан байна.

Нийслэлийн өрхийн нүүрсний хэрэглээ 2011 онд 734.3 мянган тонн буюу хамгийн их түвшинд байсан бөгөөд 2014 он хүртэл буурч, 2015 оноос өсөх хандлагатай болжээ. Нийслэлийн хэмжээнд 2019 онд 750.3 мянган тонн нүүрсийг өрхийн хэрэглээнд зарцуулсан нь өмнөх оноос 22.5 мянган тонн (3.1%)-оор нэмэгдсэн байна.

Зураг 4. Улаанбаатар хотын өрхийн нүүрсний хэрэглээ, мянган тонн, 2010-2019



Эх үүсвэр: Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, ҮСХ


Дулааны цахилгаан станцын нүүрсний хэрэглээг сүүлийн 10 жилийн байдлаар харахад 2018 онд 7734.6 мянган тонн болж хамгийн хэрэглээтэй байсан бол 2019 онд 7726.7 мянган тонн болж, 7.9 мянган тонн (0.1%)-оор буурсан байна.

Нийслэл хотын нутаг дэвсгэрийн хэмжээнд суурин газар буюу барилга байгууламжтай талбайн хэмжээ 1995 онд 4.2 хувийг эзэлж байсан бол 2018 онд 15.2 хувь болж, улам бүр нэмэгдсээр байна.

Хот суурин газрын цэцэрлэгжүүлэлт, зүлэгжүүлэлт, мод, бут нь хүмүүсийн ажиллаж амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлж, хотын агаарыг цэвэршүүлж, чийгшүүлж, шороо тоосжилтыг багасган, утаа униарыг бууруулах зэргээр хотын экосистемийг зохицуулдаг өндөр ач холбогдолтой.

Хотын цэцэрлэгжүүлж, зүлэгжүүлсэн талбайн хэмжээ 2018 оны байдлаар 12351.9 мянган м² болж, 1990 оноос ердөө 14.4 хувиар өссөн байна. Харин хотын суурин хүн ам болон барилга байгууламж, тээврийн хэрэгслийн тоо хэд дахин өсжээ.

Зураг 5. Бүртгэлтэй тээврийн хэрэгслийн тоо, мянган тээврийн хэрэгсэл, 2012-2019 он




Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- www.1212.mn

Нийслэл хотын хэмжээнд 2019 онд 568.9 мянган тээврийн хэрэгсэл байгаа нь улсын нийт бүртгэлтэй тээврийн хэрэгслийн 54.5 хувийг эзэлж, 2012 оноос 1.5 дахин, өмнөх оноос 5.8 хувиар тус тус өссөн байна.

Улаанбаатар хотын агаарын бохирдолд гэр хорооллын утаанаас гадна тээврийн хэрэгслээс шалтгаалсан хүчин зүйл нөлөөлж байна.

Зураг 6. Бүртгэлтэй тээврийн хэрэгслийн насжилт, дүнд эзлэх хувиар, 2012-2019 он



Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- www.1212.mn

Улаанбаатар хотод бүртгэлтэй тээврийн хэрэгслийн насжилтыг сүүлийн 8 жилийн дунджаар харвал 78.2 хувь нь 10, түүнээс дээш жилийн насжилттай, 12.3 хувь 7-9 жил, 5.8 хувь 4-6 жил, 3.6 хувь нь 0-3 жилийн насжилттай машин байна.

АГААРЫН БОХИРДОЛ

Улаанбаатар хотын агаарын чанарыг гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн орчмын 15 цэгт автомат багаж болон химийн аргаар агаар бохирдуулах дараах бодисуудын агууламжийг тодорхойлж байна. Тухайлбал:

- **Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO)**
- **Озон (O₃)**
- **Хүхэрлэг хий (SO₂)**

Хүхэрлэг хий SO₂ нь нүүрс, газрын тос зэрэг хүхэр агуулсан түлшний шаталт, метал боловсруулах үйл ажиллагаанаас ихэвчлэн бий болдог.

Хүхрийн давхар исэл нь нүд, хамар, хоолой, уушгины салстыг цочроон улмаар амьсгаа авахад цээжээр хөндүүр оргих, амьсгал давчдах, ханиалгах, хоолой өвдөх зэрэг шинж тэмдгүүд илэрдэг байна. Хүхэрлэг хийнд астам, архаг бронхит зэрэг амьсгалын замын архаг өвчтэй, мөн уушгины хөгжил муутай бага насны хүүхэд, өндөр настнууд хамгийн түрүүнд өртөх магадлалтай.

- **Азотын давхар исэл (NO₂)**


Азотын давхар исэл NO₂ нь өндөр температурт түлш шатах үед авто тээврийн хэрэгслийн дотоод шаталт, цахилгаан халаагуур, цахилгаан станц, химийн үйлдвэр, хог шатаах зуух зэрэг бохирдуулагч эх үүсвэрээс ялгардаг байна.

Азотын давхар исэл NO₂ нь өнгөгүй, үнэргүй хий бөгөөд агаар мандалд бор шаргал өнгөтэй болдог. Азотын давхар исэл нь уушгины эдийг цочроох ба амьсгалын замын халдварт өртөмтгий байдлыг нэмэгдүүлдэг. Азотын давхар исэл нь амьсгалын замын өвчний тохиолдлыг ихэсгэх, гуурсан хоолойн багтраа болон үрэвсэлтэй хүний мэдрэгшлийг нэмэгдүүлэх, уушгины хамгаалах механизмыг бууруулах, зүрх судасны архаг өвчнийг сэдрээх нөлөөтэй. Зүрх судасны, уушгины архаг өвчтэй хүмүүс, түүнчлэн хүүхдүүд, өндөр настнууд өртөмтгий байдаг.

- **PM_{2.5}, PM₁₀ тоосонцор**

Агаар дахь 2.5 ба 10 микрометрээс жижиг аэродинамик эквивалент диаметртэй тоосонцруудыг PM_{2.5} болон PM₁₀ гэж томъёолж байна.

Зураг 7. Тоосонцрын хэмжээний харьцуулалт⁴



Лавлагаа 1.

Хүрээлэн байгаа агаарт шууд хаягдсан эсвэл физик, химийн урвалын дүнд шинээр бий болсон бохирдуулах бодисын агууламж нь агаарын чанарын стандартаас хэтрэхийг агаарын бохирдолтой гэж үздэг байна.

Агаарын чанар гэдэг нь стандартад нийцэж байгаа эсэхийг илэрхийлэх агаарын физик, хими, биологийн цогц шинж чанар юм.

Стандарт, хэмжилзүйн газар,
Агаарын чанар, техникийн
ерөнхий шаардлага, MNS
4585:2016 стандарт, 2016 он

⁴ Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн, Баримтын цомог, Агаарын бохирдол хүний эрүүл мэндэд, 2018 он

Бид энэхүү судалгаагаар хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй бохирдуулагч бодисууд болох шаталтаас үүдэлтэй PM_{2.5}, PM₁₀ тоосонцор, хүхэрлэг хий SO₂, азотын давхар исэл NO₂-ийн талаарх мэдээллийг судалсан. Энэ бүлэгт агаар бохирдуулагч бодисуудыг үүсгэж буй хүчин зүйлс, хүлцэх агууламж, байгаа түвшин зэргийг авч үзнэ.

Цаг уур, орчны шинжилгээний газраас Улаанбаатар хотын хэмжээнд PM_{2.5}, PM₁₀ тоосонцруудыг 7-15 цэгүүдэд (2011 онд баруун дөрвөн зам, 2012-2014 онд баруун дөрвөн зам, 13-р хороолол, 2015-2016 онд 1-р хорооллоос бусад цэгт, 2017-2019 онд 15 цэгт) хэмжилт хийжээ.


Хүний эрхтэн тогтолцооны өөрчлөлтөд агаар мандалд буй олон төрлийн бодисууд дангаараа болон хамтран нөлөөлдөг. Тэдгээрээс бүх тогтолцоонд сөрөг нөлөөтэй нь PM_{2.5} болон PM₁₀ тоосонцор юм.

PM_{2.5} тоосонцрын агууламж хүлцэх хэмжээнээс илүү гарснаар амьсгалын тогтолцооны, хавдар, зүрх судасны тогтолцооны болон нөхөн үржихүйн тогтолцооны өвчлөлийн шалтгааны нэг болдог байна⁵.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжөөр PM_{2.5} тоосонцрын 24 цагийн дундаж агууламж нь 0.025 мг/м³ хүлцэх хэмжээ гэж тодорхойлдог.

PM_{2.5} тоосонцрын дундаж агууламжийг 2011-2019 оны харгалзах саруудын дунджаар, хамгийн их агууламжийг есөн жилийн дундаж утгаар авсан бол хүлцэх агууламжийг Монгол Улсын "Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага, MNS 4585:2016 стандарт"-д 24 цагийн дундаж нь 0.05 мг/м³ (нэг метр куб агаарт 0.05 миллиграм), жилийн дундаж агууламжийг 0.025 мг/м³ гэж заасны дагуу авлаа.

Зураг 8. Улаанбаатар хотын агаар дахь 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны 2011-2019 оны харгалзах саруудын дундаж, хамгийн их, хүлцэх агууламж (мг/м³)



Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- www.1212.mn


Сүүлийн 9 жилийн буюу 2011-2019 оны PM_{2.5} тоосонцрын дундаж агууламжийг харгалзах саруудын дунджаар харьцуулахад тоосонцрын агууламж 10-р сараас эхлэн дараа оны 3 дугаар сар хүртэл хүлцэх хэмжээнээс илүү байна. Эдгээр саруудад Монгол Улсын стандартын хүлцэх агууламжаас PM_{2.5} тоосонцрын дундаж агууламж 0.6-3.7 дахин их байна.

Хамгийн их агууламж нь 1-р сард 0.34 мг/м³ байгаа нь Монгол улсын стандартаас 7 дахин их, ДЭМБ-ын зөвлөмжөөс 14 дахин их байна.

⁵ WHO. WHO releases country estimates on air pollution exposure and health impact. Sep, 2016.WHO

Энэ нь Улаанбаатар хотын иргэд жилийн 6 сард нь хүлцэх хэмжээнээс хэд дахин их бохирдолтой агаараар амьсгалдаг байна.

Зураг 9. Улаанбаатар хотын агаар дахь 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны 2011-2019 оны жилийн дундаж агууламж, мг/м³




Сүүлийн есөн жилийн байдлаар харвал PM_{2.5} тоосонцрын хэмжээ 2011 онд хамгийн их буюу 0.143 мг/м³ болж, Монгол Улсын стандартад хүлээн зөвшөөрөх агууламжаас 5.7 дахин их байжээ. Энэ үзүүлэлт 2019 онд 0.115 мг/м³ болж, 2011 оноос 0.028 мг/м³ -ээр, өмнөх оноос 0.005 мг/м³-ээр буурсан хэдий ч Монгол Улсын стандартын жилийн дундаж хүлцэх агууламжаас 4.6 дахин их байна.

Монгол Улсын Засгийн газар 2018 оны 2-р сарын 28-ны өдрийн 62 дугаар тогтоолоор боловсруулаагүй нүүрсийг 2019 оны 5-р сарын 15-ны өдрөөс эхлэн Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн өрхийн хэрэглээнд зарцуулахыг хориглосон бөгөөд ингэснээр агаарын бохирдлын хэмжээг 50 хүртэл хувиар бууруулна гэж үзсэн.

2019 онд PM_{2.5} тоосонцрын агууламжийг өмнөх онтой харьцуулахад хамгийн их агууламж 1-р сард 0.34 болж, 0.01 мг/м³ (3.2 %) -ээр буурсан байна. Харин 2018 онд хамгийн их агууламж 12 дугаар сард 0.37 мг/м³ байсан бол Засгийн газрын тогтоол хэрэгжсэнээс хойш 2019 оны 12 дугаар сард 0.20 мг/м³ болж, 0.18 мг/м³ (47.2%) -ээр буурчээ. Харин 2019 оны 3,4,7 дугаар сард хамгийн их агууламж 2018 оныхоос их байсан байна.


Зураг 10. УБ хотын агаар дахь 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны хамгийн их, хүлцэх агууламж (мг/м³), 2019, 2020 оны сараар



Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- www.1212.mn

Улаанбаатар хотын PM2.5 тоосонцрын 2019 оны сарын дундаж агууламж өмнөх онтой харьцуулахад 1 дүгээр сард 0.18 мг/м³ болж, 0.01 мг/м³ (7.7%)-ээр, 12 сард 0.11 мг/м³ болж, 0.07 мг/м³ (38.3%)-ээр тус тус буурсан байна.


Зураг 11. УБ хотын агаар дахь 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны дундаж агууламж (мг/м³), 2019, 2020 оны сар бүрээр



Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- www.1212.mn

Улаанбаатар хотын агаар дахь 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны агууламжийг сүүлийн 3 жилийн эхний 3 сарын дунджаар, байршлаар харахад 2020 онд сард Амгалан, Баруун дөрвөн зам, Нисэх, Толгойт, Телевиз, 1-р хороолол орчмоор 0.055-0.107 мг/м³ хүрсэн нь агаарын чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас 0.005-0.057 мг/м³ (1.1-2.1 дахин их) -ээр давсан байна.

Зураг 12. УБ хотын агаар дахь 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны сарын дундаж агууламж (мг/м³), жил бүрийн эхний 3 сарын дунджаар, байршлаар




Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- www.1212.mn

Улаанбаатар хотын агаар дахь 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны агууламжийг сүүлийн 5 жилийн эхний 3 сарын байдлаар харвал 2016 онд дундаж агууламжийн хэмжээ хамгийн их 0.132 мг/м³ байсан бол хамгийн их агууламж 2018, 2019 онд 0.229 мг/м³ байна. 2020 оны эхний 3 сарын дунджаар дундаж агууламж 0.066 мг/м³ болж, өмнөх оноос 43.3 хувь, хамгийн их агууламж 0.119 мг/м³ болж, 48.2 хувиар тус тус буурсан байна.

Улаанбаатар хотын агаар дахь 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны дундаж агууламж 2020 оны эхний 3 сарын байдлаар өмнөх оноос буурсан хэдий ч агаарын чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас 32.8 хувь, хамгийн их агууламж 2.4 дахин их байна. Сүүлийн 10 жилийн байдлаар PM₁₀ тоосонцрын дундаж агууламжийг харгалзах саруудын дунджаар, хамгийн их агууламжийг харгалзах саруудын дундаж утгаар авсан. Монгол Улсын стандартад агаар дахь PM₁₀ тоосонцрын хүлцэх агууламж нь 24 цагт 0.1 мг/м³ (нэг метр куб агаарт 0.1 миллиграм), жилийн дундаж агууламжийг 0.05 мг/м³ гэж заасан. ДЭМБ-ын зөвлөмжид 24 цагийн дундаж хүлцэх агууламжийг 0.05 мг/м³ гэж тусгасан байна.

PM₁₀ тоосонцрын сарын дундаж агууламжийг харахад 6, 7, 8 дугаар сараас бусад сард хүлцэх агууламжаас их байсан боловч зарим жил тус саруудад ч мөн адил давж байжээ. Эдгээр арван жилийн дунджаар 9 дүгээр сараас дараа оны 5 дугаар сар хүртэл PM₁₀ тоосонцор нь Монгол Улсын стандартад заасан хүлцэх агууламжаас 1.1-3.7 дахин их, ДЭМБ-ын зөвлөмжөөс 2.1-8 дахин их, хамгийн их агууламж нь 1 дүгээр сард 15.5 дахин их байна.


Зураг 13. PM₁₀ тоосонцрын агууламж, 2010-2019 оны харгалзах саруудын дундаж, хамгийн их, хүлцэх агууламж, мг/м³



Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- www.1212.mn

Сүүлийн 10 жилийн байдлаар PM₁₀ тоосонцрын хамгийн их агууламжийг харвал 2010 оноос 2012 он хүртэл өсөж, 2012 онд хамгийн их буюу 0.769 мг/м³ болж, Монгол Улсын стандартад заасан жилийн дундаж хүлцэх агууламжаас 15.4 дахин их байсан байна. Харин тус тоосонцрын хамгийн их агууламж 2013-2017 онд буурч, дунджаар Монгол Улсын стандарт дахь хүлцэх агууламжаас 6.8 дахин их болжээ.

Зураг 14. PM₁₀ тоосонцрын агууламж, 2010-2019 оны жилийн дундаж, хамгийн их, хүлцэх агууламж (мг/м³)




Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- www.1212.mn

Харин 2019 онд PM10 тоосонцрын хамгийн их агууламж 0.229 мг/м³ болж, өмнөх оноос 0.062 мг/м³ (78.8%) буурсан ч Монгол Улсын стандарт дахь жилийн дундаж хүлцэх агууламжаас 4.6 дахин их байна.

Жилийн дундаж агууламжийн хэмжээ буурахад дулаан сарын тоосонцрын агууламж өмнөх онуудаас буурсан нь нөлөөлсөн байна. Хэдийгээр жилийн дунджаар буурсан мэт харагдаж байгаа боловч өмнөх зургуудад үзүүлсэнчлэн хүйтэрдэг саруудын хувьд өндөр хандлага хэвээр байна.

Зураг 15. Улаанбаатар хотын агаар дахь 10 микроноос бага хэмжээтэй тоосны хамгийн их агууламж (мг/м³), 2019, 2020 оны сараар




Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- www.1212.mn

PM10 тоосонцрын агууламжийг сүүлийн 5 жилийн эхний 3 сарын дунджаар харвал 2019 онд дундаж агууламж 0.182 мг/м³ болж, өмнөх оноос 6.3 хувиар нэмэгдсэн байна. Хамгийн их агууламж 2018 онд 0.470 мг/м³ болж, өмнөх оноос 7.9 хувиар нэмэгджээ.

Харин 2020 оны эхний 3 сарын дунджаар хамгийн их агууламж 0.180 мг/м³ болж, өмнөх оноос 53.0 хувь, дундаж агууламж 0.101 мг/м³ болж, 55.4 хувиар тус тус буурсан байна.


Зураг 16. Улаанбаатар хотын агаар дахь 10 микроноос бага хэмжээтэй тоосны дундаж агууламж (мг/м³), 2019, 2020 оны сараар



Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- www.1212.mn

2019 онд PM₁₀ тоосонцрын дундаж агууламж хамгийн өндөр 1 дүгээр сард 0.438 болж, өмнөх оноос 0.040 мг/м³ (8.4%)-ээр, Засгийн газрын тогтоол хэрэгжиж эхэлснээс хойш 12 дугаар сард 0.242 болж, өмнөх оноос 45.3 хувиар тус тус буурсан байна. Харин 4,7,8 дугаар сард өмнөх онтой харьцуулахад дунджаар 0.136 мг/м³ (29.7%)-ээр өссөн байна.

Зураг 17. Улаанбаатар хотын агаар дахь 10 микроноос бага хэмжээтэй тоосны сарын дундаж агууламж (мг/м³), жил бүрийн эхний 3 сарын дунджаар, байршлаар




Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- www.1212.mn

Улаанбаатар хотын агаар дахь PM₁₀ микроноос бага хэмжээтэй тоосонцрын сарын дундаж агууламжийг сүүлийн 3 жилийн эхний 3 сарын дунджаар харвал 2020 онд Баруун дөрвөн зам, Хархорин зах, 13-р хороолол, 32-ын тойрог, 1-р хороолол, орчмоор 0.104-0.150 мг/м³ хүрсэн нь агаарын чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас 0.004-0.05 мг/м³ (1.0-1.5 дахин их)-ээр давсан байна.

2019 оны хүйтний улиралд Монгол Улсын стандарт дахь жилийн дундаж хүлцэх агууламжаас PM_{2.5}, PM₁₀ тоосонцрын хамгийн их болон дундаж агууламж 2.2-4.6 дахин их байна.

Зураг 18. Тоосонцруудын 2011-2019 оны харгалзах саруудын дунджаар, хүлцэх агууламжаас давсан хувь




Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- www.1212.mn

Улаанбаатар хотын агаар дахь нарийн ширхэгт тоосонцрын агууламж 2011 онд жилийн 365 хоногийн 61.9-75.8 хувь буюу дунджаар 251 өдөр хүлцэх агууламжаас давсан байна. Энэ үзүүлэлт 2019 онд 37.2-46.5 хувь буюу дунджаар 153 өдөр болж, өмнөх оноос 5.1-

28.1 пункт буюу 61 өдрөөр буурсан байна. Эндээс харахад хотын агаар дахь нарийн ширхэгт тоосонцрын хэмжээ өмнөх оноос буурсан байна.

Зураг 19. Тоосонцруудын хүлцэх агууламжаас давсан хувь, жил бүрийн эхний 3 сарын байдлаар



Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- www.1212.mn

Улаанбаатар хотын агаар дахь 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж сүүлийн 5 жилийн эхний 3 сарын дунджаар харвал 2016 онд 83.7 хувь буюу дунджаар 25 өдөр нь хүлцэх агууламжаас давж байсан бол 2020 оны эхний 3 сарын дунджаар 55.6 хувь буюу 17 өдөр болж, өмнөх оноос 26.8 пункт буюу 8 өдрөөр буурсан байна. Харин агаар дахь 10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж 2019 оны эхний 3 сарын дунджаар хамгийн их 82.3 хувь буюу 25 өдөр нь хүлцэх агууламжаас давж байсан бол 2020 оны эхний 3 сарын дунджаар 42.9 хувь буюу 13 өдөр болж, өмнөх оноос 39.4 пункт буюу 12 өдрөөр буурчээ.


Монгол Улсын “Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага, MNS 4585:2016 стандарт”-д хүхэрлэг хийн (SO₂) 24 цагийн дундаж агууламж нь 0.05 мг/м³ (нэг метр куб агаарт 0.05 миллиграм), жилийн дундаж агууламж нь 0.020 мг/м³ гэж заасан. Хүхэрлэг хийн агууламжийг сүүлийн 10 жилийн байдлаар харвал хамгийн их агууламж 2016 онд хамгийн их буюу 0.073 мг/м³ болж, хүлцэх агууламжаас 3.6 дахин их байсан бол үүнээс хойш 2017-2018 онд дунджаар 0.048 мг/м³ болж, өмнөх оноос 34.0 хувиар буурчээ. Харин 2019 онд 0.069 мг/м³ болж, өмнөх оноос 0.028 мг/м³ (69.4%)-ээр өсөж, жилийн дундаж хүлцэх агууламжаас 3.5 дахин их болжээ.

Зураг 20. Хүхэрлэг хийн 2010-2019 оны харгалзах саруудын дундаж агууламж, мг/м³



Хүхэрлэг хийн сүүлийн 10 жилийн харгалзах саруудын дунджаар хамгийн их агууламжийг харвал хүйтний улирал болох 1-3 сар, 11-12 сард хүлцэх хэмжээнээс 1.8-2.6 дахин их, бусад саруудад бага байна. Харин дундаж агууламжийн хэмжээ 1-2, 12 дугаар сард хүлцэх хэмжээнээс 1.2-1.5 дахин их байна.


Зураг 21. Хүхэрлэг хийн (SO₂) 2010-2019 оны жилийн дундаж, хамгийн их, хүлцэх агууламж (мг/м³)



Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- www.1212.mn

Харин хүхэрлэг хийн сүүлийн 10 жилийн дундаж агууламжийг харвал бүх онуудад хүлцэх агууламжаас 0.9-84.0 хувиар их байна. Хүхэрлэг хийн дундаж агууламж 2019 онд 0.035 мг/м³ болж, өмнөх оноос 0.015 мг/м³ (73.2%)-ээр нэмэгдэж, жилийн дундаж хүлцэх агууламжаас 1.7 дахин их байна.


Зураг 22. Хүхэрлэг хийн (SO₂) хамгийн их, хүлцэх агууламж (мг/м³), 2019, 2020 оны сараар



Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- www.1212.mn

Хүхэрлэг хийн хамгийн их агууламж 2019 оны 12 дугаар сард хамгийн их буюу 0.185 мг/м³ болж, өмнөх оны мөн үеэс 0.090 мг/м³ (94.7%)-ээр нэмэгдсэн байна.

Зураг 23. Хүхэрлэг хийн сарын дундаж агууламж (мг/м³), жил бүрийн эхний 3 сарын дунджаар, байршлаар,




Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- www.1212.mn

Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн сарын дундаж агууламж 2020 оны эхний 3 сарын дунджаар Амгалан, Баруун дөрвөн зам, Баянхошуу, Хархорин зах, 32-ын тойрог, Хайлааст, Толгойт, 1-р хороолол орчмоор 0.056-0.209 мг/м³ хүрсэн нь агаарын чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас 0.006-0.159 мг/м³ (1.1-4.2 дахин)-ээр давсан байна.

Хүхэрлэг хийн агууламжийг жил бүрийн эхний 3 сарын дунджаар харвал хамгийн их болон дундаж агууламж 2016 онд хамгийн өндөр, хамгийн бага нь 2018 онд байна. 2020 оны эхний 3 сарын дунджаар хүхэрлэг хийн хамгийн их агууламж 0.127 мг/м³ болж, өмнөх оноос 43.5 хувь, дундаж агууламж 0.073 мг/м³ болж, 57.4 хувиар тус тус өссөн байна.

Зураг 24. Хүхэрлэг хий, азотын давхар ислийн хүлээн зөвшөөрөх хэмжээнээс давсан хувь, 2011-2019 он




Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- www.1212.mn

Хүхэрлэг хийн дундаж агууламжийн хүлцэх агууламжаас давсан хувийг сүүлийн 9 жилийн байдлаар харвал 2015 онд жилийн 365 хоногийн 55.6 хувь буюу 203 өдөр нь хүлцэх агууламжаас давсан бол, үүнээс хойш буурсаар 2018 онд 17.3 хувь буюу 63 өдөр болсон байна. Харин 2019 онд 23.0 хувь буюу 84 өдөр болж, өмнөх оноос 5.7 пункт буюу 21 өдрөөр нэмэгдсэн байна.

Хүхэрлэг хийн хүлцэх агууламжийн давсан хувь сүүлийн 5 жилийн эхний 3 сарын дунджаар 2016 онд хамгийн их буюу 84.1 хувь буюу 25 өдөр байсан бол 2020 оны эхний 3 сарын дунджаар 45.0 хувь буюу 13 өдөр болж, өмнөх оноос 15.1 пункт буюу 5 өдрөөр буурчээ.

Монгол Улсын “Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага, MNS 4585:2016 стандарт”-д агаар бохирдуулагч бодисын нэг болох азотын давхар ислийн жилийн дундаж хүлцэх агууламжийг 0.040 мг/м^3 , 24 цагийн дундаж хүлцэх агууламжийг 0.05 мг/м^3 гэж заасан.

Зураг 25. Азотын давхар ислийн 2010-2019 оны харгалзах саруудын дундаж агууламж (мг/м^3)



Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- www.1212.mn

Азотын давхар ислийн 2010-2019 харгалзах саруудын дунджаар харвал хамгийн их агууламж 1-5, 9-12 дугаар сард хүлцэх агууламжаас 1.1-2.1 дахин, дундаж агууламж 1-2, 11-12 сард хүлцэх агууламжаас 1.1-1.3 дахин өндөр байна.

Зураг 26. Азотын давхар ислийн (NO_2) 2010-2019 оны жилийн дундаж, хамгийн их, хүлцэх агууламж (мг/м^3)




Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- www.1212.mn

Азотын давхар ислийн хамгийн их агууламжийг сүүлийн 10 жилийн байдлаар харахад 2013 онд 0.093 мг/м^3 болж, хамгийн их буюу хүлцэх агууламжаас 2.3 дахин байсан бол үүнээс хойш 2014-2017 онд буурч, дунджаар 0.064 мг/м^3 болж, хүлцэх агууламжаас 1.6

дахин их болжээ. 2019 онд энэ үзүүлэлт 0.058 мг/м³ болж, өмнөх оноос 0.004 мг/м³ (6.3%)-ээр буурсан ч хүлцэх агууламжаас 1.5 дахин их байна.

Харин азотын давхар ислийн дундаж агууламжийг сүүлийн 10 жилийн байдлаар харахад 2010, 2015-2016, 2018-2019 онуудад хүлцэх хэмжээнээс 2.5-11.5 хувиар бага бусад онуудад 6.0-61.1 хувиар их байна.

Зураг 27. Азотын давхар ислийн (NO₂) хамгийн их, хүлцэх агууламж (мг/м³), 2019, 2020 оны сараар



Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- www.1212.mn


Азотын давхар ислийн хамгийн их агууламж 2019 оны 12 дугаар сард 0.089 мг/м³ болж, өмнөх оны мөн үеэс 0.008 мг/м³ (9.3%)-ээр өссөн байна.

Агаар дахь азотын давхар ислийн хамгийн их агууламж сүүлийн 5 жилийн эхний 3 сарын дунджаар 2017 онд 0.085 мг/м³ болж, хамгийн их байсан бол 2020 оны эхний 3 сарын дунджаар 0.076 мг/м³ болж, өмнөх оноос 0.008 мг/м³ (11.1%)-ээр нэмэгджээ.

Агаар дахь азотын давхар ислийн дундаж агууламж сүүлийн 5 жилийн эхний 3 сарын дунджаар 2017 онд 0.056 мг/м³ болж, хамгийн их байсан бол 2020 оны эхний 3 сарын дунджаар 0.055 мг/м³ болж, өмнөх оноос 0.009 мг/м³ (19.7%)-ээр мөн нэмэгдсэн байна.

Улаанбаатар хотын агаар дахь азотын давхар ислийн сарын дундаж агууламж 2020 оны эхний 3 сарын дунджаар Телевиз, 13-р хороолол, 1-р хороолол, Баруун дөрвөн зам орчмоор 0.054-0.146 мг/м³ хүрсэн нь агаарын чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас 0.004-0.096 мг/м³ (1.1-2.9 дахин их)-ээр давсан байна.

Зураг 28. Улаанбаатар хотын агаар дахь азотын давхар ислийн сарын дундаж агууламж (мг/м³), жил бүрийн эхний 3 сарын дунджаар, байршлаар



Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- www.1212.mn

Азотын давхар ислийн хүлцэх агууламжийн давсан хувийг сүүлийн 9 жилийн байдлаар харвал 2011 онд жилийн 365 хоногийн 55.8 хувь буюу 204 өдөр байсан бол үүнээс хойш бүүрсаар 2019 онд 25.5 хувь буюу жилийн 365 хоногийн 93 өдөр болж, өмнөх оноос 4.0 пункт буюу 15 өдрөөр буурчээ.

Азотын давхар ислийн хүлцэх агууламжийн давсан хувь хамгийн их нь 2016 онд 56.8 хувь буюу 17 өдөр байсан бол 2020 оны эхний 3 сарын дунджаар 41.9 хувь буюу 13 өдөр болж, өмнөх оноос 6.2 пункт буюу 2 өдрөөр мөн буурсан байна.

Зураг 29. Хүхэрлэг хий, азотын давхар ислийн хүлцэх агууламжийн давсан хувь, 2019, 2020 оны сараар



Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- www.1212.mn

Хүхэрлэг хий, азотын давхар ислийн хамгийн их агууламж 2019 онд хүлцэх хэмжээнээс 1.5-3.5 дахин их, дундаж агууламж хүхэрлэг хийн хувьд хүлцэх агууламжаас 1.7 дахин их бол азотын давхар ислийн дундаж агууламж хүлцэх хэмжээнээс бага байна.

ХҮН АМЫН ӨВЧЛӨЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг 2017-2025 оны хооронд хэрэгжүүлэхээр батлан, хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдэд эрүүл мэндийн чиглэлээр дараах 3 үзүүлэлтийг тусгасан байна.


Хүснэгт 1. Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрт тусгасан эрүүл мэндийн үзүүлэлт

Шалгуур үзүүлэлт	Нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хэрэгжилт		
		2016	2019	2025	2017	2018	2019
Амьсгалын тогтолцооны өвчин (10000 хүн ам тутамд эмнэлэгт хэвтэлтээр)	про-милль	456	448	433	433	466	478
Зүрх судасны тогтолцооны өвчин (10000 хүн ам тутамд эмнэлэгт хэвтэлтээр)	про-милль	399	393	384	384	422	427
Уушгины хатгалгаа (10000 хүн ам тутамд эмнэлэгт хэвтэлтээр)	про-милль	239	206	146	146	241	245

Тус хөтөлбөрт амьсгалын тогтолцооны өвчин (10000 хүн тутамд ногдох)-нөөр эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийг 2019 он гэхэд 448 болгох зорилт тавьсан ч 478 болж, өмнөх оноос 12-оор өсөж, үндэсний хөтөлбөрийн зорилтод хүрээгүй байна.

Зүрх судасны тогтолцооны өвчнөөр эмнэлэгт хэвтэгчдийн түвшин (10000 хүнд ногдох)-г бууруулж 2019 онд 393-д хүргэхээр тусгасан хэдий ч энэ үзүүлэлт 427 болж, өмнөх оноос 5-аар өсжээ. Уушгины хатгалгаа өвчин (10000 хүнд ногдох) 2019 онд 245 болж, өмнөх оноос 4-өөр өсөж зорилтот түвшинд мөн хүрээгүй байна.

Зураг 30. Амбулаторийн өвчлөлийн тохиолдол, мянган хүн



Эрүүл мэндийн яамны 2019 оны мэдээгээр улсын хэмжээнд амбулаторийн өвчлөлийн тохиолдол 3.6 саяд (давхардсан тоогоор) хүрч, 10 жилийн өмнөхөөс 2.2 дахин, өмнөх оноос 18.3 хувиар өссөн бол Улаанбаатар хотод 1.9 сая болж, 10 жилийн өмнөхөөс 2.6 дахин, өмнөх оноос 20.0 хувь, хөдөө, орон нутагт 1.7 сая болж, 10 жилийн өмнөхөөс 1.6 дахин, өмнөх оноос 16.4 хувиар тус тус өссөн байна.

Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Зураг 31. Амбулаторийн өвчлөлийн тохиолдол, байршлаар, дүнд эзлэх хувиар, 2010-2019 он


Амбулаторийн өвчлөлийн тохиолдлын хандлагыг байршлаар авч үзвэл, сүүлийн 10 жилийн хугацаанд Улаанбаатар хотын бүртгэгдсэн өвчлөлийн улсын дүнд эзлэх хувь 2013 оноос өсөж, аймгуудын хувьд буурсан хандлагатай байна.

Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Амбулаторийн өвчлөлийн тохиолдлыг өвчний ангиллаар авч үзвэл, Монгол Улсын хэмжээнд сүүлийн 10 жилийн байдлаар амьсгалын тогтолцооны, хоол боловсруулах эрхтний, зүрх, судасны тогтолцооны, мэдрэлийн тогтолцооны өвчнүүд тэргүүлж, энэ хандлага Улаанбаатар хотод ижил байна.

Хүснэгт 2. Өвчлөлийн тэргүүлэх шалтгаан, дүнд эзлэх хувиар, 2010, 2019 он

■ Аймаг ■ Улаанбаатар



Тэргүүлэх өвчлөлүүд	Улс		Улаанбаатар	
	2010	2019	2010	2019
Нийт	100.0	100.0	100.0	100.0
Амьсгалын тогтолцооны өвчин	19.3	18.6	14.9	15.2
Хоол боловсруулах эрхтний өвчин	14.7	16.3	13.3	14.9
Зүрх, судасны тогтолцооны өвчин	11.8	11.7	10.1	10.4
Шээс бэлгэсийн тогтолцооны өвчин	12.3	9.9	9.6	9.3
Мэдрэлийн тогтолцооны өвчин	5.5	6.6	5.6	6.4
Бусад өвчин	36.3	36.9	46.4	43.9

Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл


Улаанбаатар хотын хувьд сүүлийн жилүүдэд хүн амын төвлөрөл ихсэж, агаарын бохирдлын асуудал хурцаар тавигдаж байгаатай холбогдуулан хүний эрүүл мэнд ялангуяа амьсгалын тогтолцоо, зүрх судасны тогтолцооны өвчлөл болон нөхөн

үржихүйн эрүүл мэндийн үзүүлэлтүүд хэрхэн өөрчлөгдөж байгааг дараах хэсэгт тусгайлан авч үзье.

Зураг 32. Агаарын бохирдлын хүний эрүүл мэндэд үзүүлэх хор, нөлөө⁶

Амьсгалын тогтолцооны өвчлөл


Улаанбаатар хотын 10000 хүн амд ногдох амьсгалын тогтолцооны өвчлөл 2013-2016 оны



хооронд өсөж улсын дунджаас 17-270-аар өндөр, 2017-2019 онд 131-151-ээр бага байна.

Улсын хэмжээнд амьсгалын тогтолцооны өвчлөл (10000 хүн амд ногдох) 2019 онд 2099 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 1.4 дахин, өмнөх оноос 380-аар тус тус өссөн байна. Энэ үзүүлэлт Улаанбаатар хотод 2019 онд 1961 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 1.3 дахин, өмнөх оноос 373-аар мөн өсжээ.

Зураг 33. Амьсгалын тогтолцооны өвчлөл, 10000 хүн амд ногдохоор, 2010-2019 он



Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Улаанбаатар хотын амбулаторид бүртгэгдсэн нийт өвчлөлийн тохиолдлын түвшин сүүлийн 5 жилийн эхний 3 сарын дунджаар 2019 онд 1041 болж, хамгийн их байсан бол

⁶ Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн, Баримтын цомог, Агаарын бохирдол хүний эрүүл мэндэд, 2018 он

2020 оны эхний 3 сарын дунджаар 963 болж, 78-аар буурчээ. Амьсгалын тогтолцооны өвчний түвшин 2016 онд 202 болж, хамгийн их байсан бол 2020 оны эхний 3 сарын дунджаар 144 болж, өмнөх оноос 22-оор буурсан байна.


Зураг 34. Амбулаторид бүртгэгдсэн нийт өвчлөл, амьсгалын тогтолцооны өвчлөл, 10000 хүн амд ногдохоор, жил бүрийн эхний 3 сарын байдлаар



Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл


Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлтөөр олгодог амьсгалын замын үйл ажиллагаанд нөлөөлөх эмийн борлуулалт Улаанбаатар хотын хэмжээнд 2020 оны эхний 3 сарын дунджаар 7.3 сая төгрөг болж, өмнөх оноос 7.4 сая төгрөг (2 дахин)-өөр буурсан байна.

Зураг 35. ЭМД-ын сангаас хөнгөлөлтөөр олгодог борлуулалт, сая төгрөг, жил бүрийн эхний 3 сарын байдлаар, УБ хот



Эх үүсвэр: ЭМЯ, ЭМДЕГ-ын мэдээлэл

Зураг 36. УБ хотын 0-17 насны хүүхдийн эмийн эмчилгээний зардал сая төгрөг, 2018-2019 он



Улаанбаатар хотын 0-17 насны хүүхдүүдийн амьсгалын тогтолцооны өвчний тохиолдлын эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн эмчилгээний зардал 2019 онд нийт 4989.0 сая төгрөг болж өмнөх оноос 436.2 сая (9.6%) төгрөгөөр нэмэгджээ. Эмчилгээний зардлыг сараар харвал 2019 оны 12 дугаар сард 836.7 сая болж, хамгийн өндөр бөгөөд өмнөх оноос 141.8 сая (20.4%) төгрөгөөр нэмэгджээ.


Зураг 37. Улаанбаатар хотын 0-17 насны хүүхдийн амьсгалын тогтолцооны өвчний тохиолдол, зарцуулсан эмчилгээний зардал, жил бүрийн эхний 3 сарын байдлаар



Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Улаанбаатар хотын 0-17 насны хүүхдийн амьсгалын тогтолцооны өвчний тохиолдол болон эмчилгээний зардлыг сүүлийн 5 жилийн эхний 3 сарын дунджаар харвал 2016 онд хамгийн их буюу 266 хүүхдэд 8.9 сая төгрөгийн эмчилгээ хийжээ. Харин 2020 оны эхний 3 сарын дунджаар 116 хүүхдэд 4.7 сая төгрөгийн эмчилгээ хийсэн нь өмнөх оноос 20 хүүхэд буюу 1.4 сая төгрөгөөр нэмэгджээ.

Зураг 38. Улаанбаатар хотын 0-17 насны хүүхдийн амьсгалын тогтолцооны өвчнөөр эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн тохиолдол, байршлаар, дүнд эзлэх хувиар, 2018-2019 он




Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Улаанбаатар хотын 0-17 насны хүүхдийн амьсгалын тогтолцооны өвчнөөр эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн тохиолдлыг 2018 оны байдлаар, байршлаар харвал хамгийн их буюу 21.7 хувь нь Баянгол дүүрэг байсан бол 2019 онд Баянзүрх дүүрэгт 21.9 хувь байна.

Улаанбаатар хотын хувьд 2019 оны байдлаар хүн амын амьсгалын тогтолцооны өвчлөлд хамгийн их буюу 17.9 хувийг хатгалгаа өвчин, үүний дотор 5 хүртэлх насны хүүхдийн хатгалгаа 68.7 хувийг эзэлж байна. Үүний дараагаар цочмог бронхит (acute bronchitis) өвчин орж байна. Энэ өвчин 2019 оны байдлаар амьсгалын тогтолцооны өвчлөлийн 14.4 хувь, үүний дотор 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөл 69.4 хувийг эзэлж байна.

Улаанбаатар хотын амьсгалын тогтолцооны зарим өвчнөөс цочмог бронхит өвчин 2010 оноос эрчимтэй өсөж 10000 хүн амд ногдох өвчин 2019 онд 282 болж, 2010 оноос 4.9 дахин, өмнөх оноос 42-оор нэмэгдсэн байна. Хатгалгаа нь жил ирэх тусам өсөх хандлагатай байсан хэдий ч 2015 онд 176 болж буурснаа 2016 оноос эргээд өссөн байна.

Зураг 39. Улаанбаатар хотын хүн амын амьсгалын тогтолцооны өвчин, зарим өвчин, 10000 хүн амд ногдохоор, 2010-2019 он



Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Хатгалгаа өвчний түвшин (10000 хүн амд ногдох) 2019 онд 351 болж, 2010 оноос 2.0 дахин, өмнөх оноос 30-аар өсжээ. Эдгээр өвчний 10000 хүн амд ногдох түвшин нь хүн амын өсөлтийн нөлөөг арилгасан үзүүлэлт учраас агаарын бохирдол болон өөр бусад хүчин зүйлээс шалтгаалан өссөн байх боломжтой юм.

Амьсгалын тогтолцооны зарим өвчнийг сараар авч үзэхэд сүүлийн таван жилийн дунджаар хатгалгаа өвчний түвшин (10000 хүн амд ногдох) хамгийн их нь 1 болон 12 дугаар сард дунджаар 44 байгаа нь зуны 7, 8 дугаар сарын дунджаас 4.7 дахин их байна. Мөн цочмог бронхит өвчний түвшин (10000 хүн амд ногдох) хамгийн их нь 1 болон 11-12 дугаар сард дунджаар 27 байгаа нь зуны 7, 8 дугаар сарын дунджаас 2.7 дахин их байна.


Зураг 40. Улаанбаатар хотын хүн амын амьсгалын тогтолцооны зарим өвчин, 10000 хүнд ногдохоор, 2015-2019 оны харгалзах саруудын дунджаар



Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Хатгалгаа өвчний түвшинг өмнөх оны саруудын дундажтай харьцуулахад 2019 онд 29 болж, 2-оор нэмэгдсэн байна. 2019 онд хатгалгаа өвчний түвшин 1, 12 дугаар сарын дунджаар 60 болж, өмнөх оны мөн үеийн дунджаас 15-аар нэмэгдсэн байна.

Зураг 41. Улаанбаатар хотын хатгалгаа өвчний түвшин, 10000 хүнд ногдохоор, 2018-2019 он, сараар



Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Хатгалгаа өвчний түвшин (10000 хүнд ногдох)-г сүүлийн 5 жилийн эхний 3 сарын дунджаар 2016 онд 36 болж хамгийн өндөр байсан бол 2020 оны эхний 3 сарын дунджаар 28 болж, өмнөх оноос 6-аар буурсан байна. Сүүлийн 5 жилийн байдлаар хатгалгаа өвчний түвшин 2019 оны 1 дүгээр сард хамгийн өндөр 57, хамгийн бага нь 2020 оны 3 дугаар сард 8 байна.

Зураг 42. Улаанбаатар хотын хатгалгаа, цочмог бронхит өвчний түвшин, 10000 хүнд ногдохоор, жил бүрийн эхний 3 сарын байдлаар




Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Цочмог бронхит өвчний түвшин (10000 хүнд ногдох)-г сүүлийн 5 жилийн байдлаар сараар харвал 2016 оны 3 дугаар сард 35, хамгийн бага нь 2020 оны 3 дугаар сард 8 байна. Энэ үзүүлэлт сүүлийн 5 жилийн эхний 3 сарын дунджаар 2016 онд 29 болж, хамгийн өндөр байсан бол 2020 оны эхний 3 сарын дунджаар 21 болж, өмнөх онтой адил түвшинд байна.

Амьсгалын тогтолцооны зарим өвчнийг насны бүлгээр авч үзвэл 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөлийн түвшин бусад насныхнаас өндөр байна. Тухайлбал, цочмог бронхит өвчин бусад насны бүлгийн хүн амын дундажтай харьцуулахад 21 дахин, хатгалгаа 15 дахин их байна.

Зураг 43. Амьсгалын тогтолцооны зарим өвчин, насны бүлгээр, 10 000 хүн амд ногдохоор, 2019 он



Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Агаарын бохирдол нь хүн амын ялангуяа 5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын эрхтэн тогтолцооны өвчлөлийн шалтгаан болж байгааг дээрх үр дүнгээс харж болохоор байна.

Амьсгалын тогтолцооны өвчлөлөөр 5 хүртэлх насны хүүхэд ихээр өвчилж байгаа нь хүүхдийн цээжний хэнхэрцэг, өрц сул хөгжилтэй байдгаас уушгины агааржилт муу, уушгины үлдэгдэл агаарын эзлэхүүн бага байдагтай холбоотой юм. Уушгины цулцангийн хөгжил нь 3 настайд бүрэн хөгжиж цаашдаа хэмжээ нь томордог байна. Бохир агаар нь ураг болон 5 хүртэлх насны хүүхдэд сөрөг нөлөөтэй, цаашлаад ужиг өвчин, нярайн эндэгдэл, нялхсын эндэгдлийн шалтгаан болдог гэж нотолсон байдаг⁷.

Тав хүртэлх насны хүүхдийн амьсгалын тогтолцооны өвчлөлийн тохиолдол 2019 онд 116.3 мянга болж, сүүлийн 10 жилийн дунджаас 26.4 мянга (29.9%)-аар, өмнөх оноос 11.6 мянга (11.0%)-аар тус тус нэмэгджээ. Тав хүртэлх насны хүүхдийн хатгалгаа өвчний тохиолдол 2019 онд 35.1 мянга болж, амьсгалын тогтолцооны өвчний 30.2 хувийг эзэлж, сүүлийн 10 жилийн дунджаас 3.5 пунктээр нэмэгдэж, өмнөх оноос 0.9 пунктээр буурсан байна.

Тав хүртэлх насны хүүхдийн амьсгалын тогтолцооны өвчний түвшин (10000 хүүхдэд ногдох) 2019 онд 6405 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 699-өөр, өмнөх оноос 593-аар тус тус нэмэгджээ. Харин 5 хүртэлх насны хүүхдийн хатгалгаа өвчний түвшин 2019 онд 1934 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 487-гоор, өмнөх оноос 126-гаар тус тус нэмэгдсэн байна.

⁷НҮБ-ын Хүүхдийн сан, Хүүхдийн эрүүл мэндэд агаарын бохирдлын үзүүлэх нөлөө, шийдвэрлэх арга зам, 2016 он
33

Зураг 44. Улаанбаатар хотын 5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын болон хатгалгаа өвчний түвшин, 10000 хүүхдэд ногдохоор, 2010-2019 он



Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл


Тав хүртэлх насны хүүхдийн амьсгалын тогтолцооны өвчний түвшин 2015 онд хамгийн их буюу 7791, хамгийн бага нь 2012 онд 3701 байна.

Харин тав хүртэлх насны хүүхдийн хатгалгаа өвчний түвшин (10000 хүүхдэд ногдох) 2019 онд хамгийн их буюу 1934, хамгийн бага нь 2015 онд 832 байна.

Сүүлийн 10 жилийн байдлаар 10000 хүн амд ногдох хатгалгаа өвчнөөр нас баралтын түвшин 2010-2017 онд харьцангуй тогтмол 1, 2018-2019 онд 2 байгаа хэдий ч сүүлийн 10 жилийн дунджаас 1-ээр нэмэгдсэн байна. Сүүлийн 10 жилийн дунджаар 5 хүртэлх насны хүүхдийн хатгалгаагаар нас баралт нийт нас баралтын түвшнээс 4-өөр их байна.

Тав хүртэлх насны 10000 хүүхдэд ногдох хатгалгаагаар нас баралт 2011 онд хамгийн их буюу 8 байсан бол үүнээс хойш буурч 2017-2019 онд 3 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 2-оор буурчээ.


Зураг 45. Улаанбаатар хотын хатгалгаа өвчнөөр нас барсан нийт хүн ам, 5 хүртэлх насны хүүхэд, (10000 хүн амд ногдох) 2010-2019 он



Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Улаанбаатар хотын 5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох хатгалгаа өвчнийг сүүлийн 5 жилийн байдлаар, сараар, агаарын бохирдлын дундаж үзүүлэлттэй харьцуулбал, агаарын бохирдол ихтэй саруудад ялангуяа PM₁₀ тоосонцрын дундаж хэмжээ ихсэх үед хатгалгаа өвчлөлийн түвшин нэмэгдэж байгааг дараах зургаас харж болно.

Зураг 46. Тав хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох хатгалгаа өвчин, сараар, 2015-2019 он



Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Улаанбаатар хотын 5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох хатгалгаа өвчлөлийн түвшин сүүлийн 5 жилийн саруудын дунджаар 12 дугаар сард хамгийн их буюу дунджаар 30, хамгийн бага нь 7-8 дугаар сард дунджаар 3 байна.

Тав хүртэлх насны хүүхдийн хатгалгаа өвчний түвшинг 2020 оны эхний 3 сарын байдлаар харвал дунджаар 14 болж, өмнөх оны мөн үеийн дунджаас 4-өөр буурсан байна.


Зураг 47. Тав хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох хатгалгаа өвчний түвшин, жил бүрийн эхний 3 сарын байдлаар



Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Агаарын бохирдолтой холбогдох амьсгалын тогтолцооны өвчлөлийн нэг бол уушгины архаг бөглөрөл юм. Улаанбаатар хотын 10000 хүн амд ногдох уушгины архаг бөглөрөл өвчнийг сүүлийн 5 жилийн байдлаар сараар харвал хүйтний улирал буюу агаарын бохирдол ихтэй саруудад нэмэгдэж байгаа нь доорх зургаас харагдаж байна.


Зураг 48. Улаанбаатар хотын 10 000 хүн амд ногдох уушгины архаг бөглөрөл өвчин, сараар, 2015-2019 он



Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Уушгины архаг бөглөрөл өвчний түвшин 2020 оны эхний 3 сарын дунджаар 17 болж, өмнөх оны мөн үеийн дунджаас 1-ээр буурсан байна. Уушгины архаг бөглөрөл өвчний түвшин 2020 оны 1 дүгээр сард хамгийн их буюу 27 болж, сүүлийн 5 жилийн мөн үеийн дунджаас 11-ээр их байна.


Зураг 49. Улаанбаатар хотын 10000 хүн амд ногдох уушгины архаг бөглөрөл өвчин, жил бүрийн эхний 3 сарын байдлаар



Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Уушгины хавдар элэг, ходоодны өвчлөлийн дараа ордог бөгөөд Улаанбаатар хотын 10 000 хүн амд ногдох уушгины хавдрын өвчлөл 2019 онд 12 болж, өмнөх оноос 2-оор буурсан байна. Харин сүүлийн 5 жилийн байдлаар сараар харвал, агаарын бохирдол их байсан сарын дараагийн саруудад өндөр байх хандлага ажиглагдаж байна.


Зураг 50. Улаанбаатар хотын 10000 хүн амд ногдох уушгины хавдар, сараар, 2015-2019 он



Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

2018-2019 онд уушгины хавдрын өвчлөл (10000 хүнд ногдох) өмнөх 2017 оны дунджаас 2 дахин буурсан байна. Харин 2019 онд уушгины хавдрын өвчлөл (10000 хүнд ногдох) 12 сарын дунджаар өмнөх онтой харьцуулахад адил түвшинд байна.

Зураг 51. Улаанбаатар хотын 10000 хүн амд ногдох уушгины хавдар, сараар, 2015-2019 он



Уушгины хавдрын өвчлөлийн түвшин (10000 хүнд ногдох) сүүлийн 5 жилийн эхний 3 сарын дунджаар 2018 онд 2 болж, хамгийн өндөр байсан бол 2020 оны эхний 3 сарын дунджаар 1 болж, өмнөх оны мөн үетэй адил түвшинд байна.

Нөхөн үржихүйн тогтолцооны өвчлөл

Агаарын бохирдол ньургийн өсөлт, хөгжил саарах, жин багатай, дутуу тээлттэй хүүхэд төрөх, зулбах зэрэгт нөлөөлдөг⁸ болох нь судалгаагаар нотлогдсон.

⁸НҮБ-ын Хүүхдийн сан, Хүүхдийн эрүүл мэндэд агаарын бохирдлын үзүүлэх нөлөө, шийдвэрлэх арга зам, 2016 он

Төрөлхийн хөгжлийн гажиг нь удамшлын, жирэмсэн үе болон төрөхөөс өмнөх эхийн эрүүл мэндийн байдлаас шалтгаалан үүсдэг байна.

Агаарын бохирдолтой холбогдох нөхөн үржихүйн тогтолцооны өвчлөл болох 1000 амьд төрөлтөд ногдох дутуу төрөлтийг сүүлийн 5 жилийн байдлаар харвал, 2018 онд 81 болж хамгийн их байгаа бол, 2019 онд 72 болж, өмнөх оноос 9-өөр буурчээ. 1000 амьд төрөлтөд ногдох төрөлхийн гажигтай хүүхэд 2019 онд 8 болж, өмнөх оноос 2-оор нэмэгджээ. Амьгүй төрөлтийн түвшин 2019 онд 6 болж, өмнөх онтой адил түвшинд байна.

Зураг 52. Улаанбаатар хотын 1000 амьд төрөлтөд ногдох дутуу төрөлт, төрөлхийн гажигтай хүүхэд, амьгүй төрөлт, 2015-2019 он, 2020 оны эхний 3 сарын байдлаар



Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Төрөлхийн гажигтай төрөлтийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох) болон амьгүй төрөлтийн түвшинг сүүлийн 5 жилийн байдлаар, сараар, агаарын бохирдлын үзүүлэлтэй харьцуулж харахад бохирдол ихтэй сарын дараагийн саруудад төрөлхийн гажиг болон амьгүй төрөлтийн түвшин нэмэгдсэн байгааг харж болно.

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг сүүлийн 5 жилийн байдлаар сараар харвал 12, 1 дүгээр сард хамгийн өндөр байгаа бол 1000 амьд төрөлтөд ногдох төрөлхийн гажигтай төрсөн хүүхэд сарын хувьд харилцан адилгүй 2018 оны 12 дугаар сард хамгийн их 14, 2015 оны 10 дугаар сар, 2019 оны 1 дүгээр сард 12 байна.

Зураг 53. Улаанбаатар хотын 1000 амьд төрөлтөд ногдох төрөлхийн гажигтай төрсөн хүүхэд, амьгүй төрөлтийн түвшин, сараар, 2015-2019



Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Амьгүй төрөлтийн түвшинг сүүлийн 5 жилийн байдлаар, сараар харвал 2015 оны 9-11 дүгээр сард хамгийн өндөр буюу 10-12 байна. Энэ үзүүлэлт 2019 оны 2 дугаар сард хамгийн их 9 байгаа нь өмнөх оны мөн үеэс 5-аар их байна.

Зураг 54. Улаанбаатар хотын 1000 амьд төрөлтөд ногдох төрөлхийн гажигтай төрсөн хүүхэд, амьгүй төрөлтийн түвшин, жил бүрийн эхний 3 сарын байдлаар



Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Төрөлхийн гажигтай төрсөн хүүхэд (1000 амьд төрөлтөд ногдох) 2020 оны эхний 3 сарын дунджаар 9 болж, өмнөх оны мөн үетэй адил түвшинд, амьгүй төрөлтийн түвшин 6 болж, өмнөх оны мөн үеэс 1-ээр буурсан байна.

Нөхөн үржихүйн тогтолцооны бас нэг үзүүлэлт бол 1000 амьд төрөлтөд ногдох дутуу төрөлт (22-36 долоо хоногтой) бөгөөд энэ үзүүлэлт агаарын бохирдол ихтэй саруудад өсөж байгаа нь зургаас харагдаж байна.

Зураг 55. Улаанбаатар хотын 1000 амьд төрөлтөд ногдох дутуу төрөлтийн түвшин, сараар, 2015-2019 он



Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Улаанбаатар хотын 1000 амьд төрөлтөд ногдох дутуу төрөлтийг сүүлийн 5 жилийн байдлаар сараар харвал харилцан адилгүй байна. 2015 оны 3 дугаар сард 98 болж хамгийн их байсан бол 2019 оны 5, 7 дугаар сард 82-83 болж хамгийн их байна.

Зураг 56. Улаанбаатар хотын 1000 амьд төрөлтөд ногдох дутуу төрөлтийн түвшин, жил бүрийн эхний 3 сарын байдлаар




Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Улаанбаатар хотын 1000 амьд төрөлтөд ногдох дутуу төрөлтийн түвшинг, сүүлийн 5 жилийн байдлаар, эхний 3 сараар харвал 2018 онд 87 болж, хамгийн өндөр байсан бол 2020 оны эхний 3 сарын дунджаар 76 болж, өмнөх оны мөн үеэс 11-ээр нэмэгдсэн байна.

Сүүлийн жилүүдэд өсөлтгүй жирэмсний тохиолдлын талаар ихээхэн ярих болсон. Өсөлтгүй жирэмслэлт гэдэг нь ямар нэг шалтгааны улмаас ураг амьгүй болж, ургийн хөгжил зогсохыг ойлгоно. Өсөлтгүй жирэмслэлтийн гол шалтгаан нь эхийн эрүүл мэндийн байдал мөн амьдарч байгаа орчин, амьсгалж буй агаар, хоол, хүнс зэрэг олон зүйлээс шалтгаалдаг байна.

Зураг 57. 1000 амьд төрөлтөд ногдох өсөлтгүй жирэмслэлт, 2015-2019 он



Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл


Улсын хэмжээнд сүүлийн 5 жилийн байдлаар 1000 амьд төрөлтөд ногдох өсөлтгүй жирэмслэлтийн тохиолдлыг харахад 2015-2017 онд тасралтгүй өсөж, 2018 онд 54 болж, өмнөх оноос 4-өөр буурсан байна. Харин 2019 онд энэ үзүүлэлт 59 болж, өмнөх оноос 5-аар нэмэгдсэн байна. Энэ хандлага Улаанбаатар хотод ижил байгаа ч улсын дунджаас дээгүүр тухайлбал, 2019 онд 1000 амьд төрөлтөд ногдох өсөлтгүй жирэмслэлт 76 болж, улсын дунджаас 17-гоор, өмнөх оноос 7-гоор тус тус их байна.

Сүүлийн 5 жилийн дунджаар өсөлтгүй жирэмслэлтийн тохиолдлын 52.0 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна.

Улаанбаатар хотын 1000 амьд төрөлтөд ногдох өсөлтгүй жирэмсний тохиолдлыг сүүлийн 5 жилийн байдлаар агаарын бохирдлын сарын дундаж үзүүлэлттэй

харьцуулахад мөн дээрх хандлагуудтай ижил агаарын бохирдол ихтэй сарын дараагийн саруудад өсөлтгүй жирэмслэлт нэмэгдэж байгаа нь дараах зургаас харагдаж байна.

Зураг 58. Улаанбаатар хотын 1000 амьд төрөлтөд ногдох өсөлтгүй жирэмслэлт, сараар, 2015-2019 он



Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Улаанбаатар хотын 1000 амьд төрөлтөд ногдох өсөлтгүй жирэмслэлт 2019 оны 1-5 дугаар сарын дунджаар хамгийн их буюу 80 болсон нь 2018 оны дунджаас 5-аар их байна. 2019 онд хамгийн их нь 1 дүгээр сард 98, хамгийн бага нь 4, 11 дүгээр сард 64-65 байна.

Зураг 59. Улаанбаатар хотын 1000 амьд төрөлтөд ногдох өсөлтгүй жирэмслэлт, жил бүрийн эхний 3 сарын байдлаар



Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл


Улаанбаатар хотын 1000 амьд төрөлтөд ногдох өсөлтгүй жирэмслэлтийн түвшинг сүүлийн 5 жилийн эхний 3 сарын байдлаар харвал 2017 онд дунджаар 90 болж, хамгийн өндөр байсан бол 2020 оны эхний 3 сарын дунджаар 79 болж, өмнөх оноос 7-гоор буурчээ.

Зүрх судасны тогтолцооны өвчлөл

Улаанбаатар хотын хувьд зүрх судасны тогтолцооны өвчлөл нь өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байна. Улаанбаатар хотод 2019 оны байдлаар хүн амын зүрх судасны тогтолцооны өвчлөлийн 33.1 хувийг анхдагч даралт ихсэх өвчин, 19.8 хувийг зүрхний шигдээс өвчин эзэлж байна. Зүрх судасны өвчлөлөөр өвчлөгчдийг насны бүлгээр харвал, 90 гаруй хувийг 35-аас дээш насныхан эзэлж байна.

Сүүлийн 10 жилийн байдлаар зүрх судасны тогтолцооны зарим өвчлөл болох 10000 хүнд ногдох анхдагч даралт ихсэх өвчин, зүрхний шигдээс өвчин 2010 оноос хойш өсөх хандлагатай байна. Тухайлбал, 10000 хүн амд ногдох анхдагч даралт ихсэх өвчин 2019 онд 433 болж, 10 жилийн дунджаас 1.3 дахин, өмнөх оноос 1.2 дахин, харин зүрхний шигдээс өвчин 2019 онд 265 болж, 10 жилийн дундаж болон өмнөх оноос тус бүр 1.2 дахин өссөн байна. Харин 10 000 хүнд ногдох тархинд цус харвалт өвчин 2010-2012 онд дунджаар 20, 2013-2017 онд дунджаар 18, 2019 онд 16 болж, өмнөх оноос 1-ээр буурсан байна.

Зураг 60. Улаанбаатар хотын 10 000 хүн амд ногдох зүрх, судасны тогтолцооны зарим өвчин, 2010-2019




Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Зүрх судасны тогтолцооны зарим өвчлөлийг сүүлийн 5 жилийн байдлаар, сараар, агаарын бохирдлын үзүүлэлттэй харьцуулан харья.

Анхдагч даралт ихсэх өвчнийг агаарын бохирдлын үзүүлэлттэй харьцуулахад агаарын бохирдол өндөр байсан дараагийн сараас өвчлөл ихэссэн байгаа зүй тогтол ажиглагдаж байна /зураг 18/.

Улаанбаатар хотын 10 000 хүн амд ногдох анхдагч даралт ихсэх өвчин 2019 оны 4 дүгээр сард хамгийн өндөр 48, хамгийн бага нь 12 дугаар сард 29 байна.

Зураг 61. Улаанбаатар хотын 10000 хүн амд ногдох анхдагч даралт ихсэх өвчин, сараар, 2015-2019 он



Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Анхдагч даралт ихсэх өвчлөлийн түвшинг сүүлийн 5 жилийн эхний 3 сарын дунджаар харвал 2017 онд 43 болж хамгийн их байсан бол 2020 оны эхний 3 сарын дунджаар 30 болж, өмнөх оноос 10-аар буурсан байна.


Зураг 62. Улаанбаатар хотын 10000 хүн амд ногдох анхдагч даралт ихсэх өвчин, эхний 1-3 сараар, 2015-2019 он



Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Зүрхний шигдээс өвчний хувьд бусад өвчлөлтэй адил зүй тогтолтой байна. Улаанбаатар хотын 10000 хүн амд ногдох зүрхний шигдээс өвчин 2019 оны 3,4 дүгээр сард хамгийн их буюу 27-28, хамгийн бага нь 7,8 сард 17-18 байна.

Зураг 63. Улаанбаатар хотын 10000 хүн амд ногдох зүрхний шигдээс өвчин, сараар, 2015-2019 он



Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Тайлбар: Зүрхний шигдээс өвчинд зүрхний булчингийн цочмог шигдээс болон бусад зүрхний шигдээс өвчнүүдийг оруулсан.

Зүрхний шигдээс өвчний түвшин (10000 хүн амд ногдох)-г сүүлийн 5 жилийн эхний 3 сарын дунджаар харвал 2017, 2019 онд 23 болж хамгийн өндөр байсан бол 2020 оны эхний 3 сарын дунджаар 22 болж, 1-ээр буурсан байна.

Зураг 64. Улаанбаатар хотын 10000 хүн амд ногдох зүрхний шигдээс өвчин, жил бүрийн эхний 3 сарын байдлаар



Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Дээрх хэсэгт агаарын бохирдол ихтэй үед хүн амын өвчлөл ямар байгааг харуулсан бол Улаанбаатар хотын агаарын бохирдлын төлөв, байдал сүүлийн жилүүдийн өөрчлөлтийг дараах хэсэгт авч үзлээ.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоол хэрэгжсэнээс хойш Улаанбаатар хотын агаар дахь 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны хамгийн их агууламж 2019 оны 12 дугаар сард 0.20 мг/м^3 болж, өмнөх оны мөн үеэс 0.18 мг/м^3 (47.2%)-ээр буурсан байна.

Улаанбаатар хотын агаар дахь 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны дундаж агууламж 2020 оны эхний 3 сарын дунджаар 0.066 мг/м^3 болж, өмнөх оноос 43.3 хувь, хамгийн их агууламж 0.119 мг/м^3 болж, 48.2 хувиар тус тус буурсан ч Монгол Улсын стандарт дахь хүлцэх агууламжаас 32.7%-2.4 дахин их байна.

Улаанбаатар хотын агаар дахь нарийн ширхэгт тоосонцрын агууламж 2011 онд жилийн 365 хоногийн 61.9-75.8 хувь буюу дунджаар 251 өдөр хүлцэх хэмжээнээс давж байсан бол 2019 онд 37.2-46.5 хувь буюу дунджаар 153 болж, өмнөх оноос 5.1-28.1 хувь буюу 61 өдрөөр буурсан байна.

Монгол Улсын Засгийн газар 2018 оны 2-р сарын 28-ны өдрийн 62 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн өрхийн хэрэглээнд 2019 оны 5-р сарын 15-ны өдрөөс эхлэн боловсруулаагүй нүүрсийг хэрэглэхийг хориглож, сайжруулсан нүүрсийг хэрэглэх болсон.

Агаар бохирдуулагч бусад бодисын дундаж агууламж 2020 оны эхний 3 сарын дунджаар өмнөх онтой харьцуулахад хүхэрлэг хий 50 гаруй хувь, азотын давхар исэл 20 орчим хувиар тус тус нэмэгдсэн байна.

Агаарын бохирдлыг бий болгодог хүчин зүйлс болох хотын хүн амын төвлөрөлтэй холбоотой өрхийн нүүрсний хэрэглээ, тээврийн хэрэгслийн тоо зэрэг үзүүлэлтүүд өмнөх оноос өссөн байна.

Сүүлийн 10 жилийн дунджаар шилжих хөдөлгөөнөөс шалтгаалан Монгол Улсын нийт өрхийн 42.8 хувийг Улаанбаатар хотын өрх эзэлж байна. Нийслэлийн хэмжээнд 2019 онд өрхийн хэрэглээнд 750.3 мянган тонн нүүрсийг зарцуулсан нь өмнөх оноос 22.5 мянган тонн (3.1%)-оор нэмэгдсэн байна.

Монгол улсын нийт тээврийн хэрэгслийн 54.5 хувь нь Улаанбаатар хотод байна. Улаанбаатар хотын бүртгэлтэй тээврийн хэрэгслийн 78.2 хувь нь 10, түүнээс дээш жилийн насжилттай, 12.3 хувь 7-9 жил, 5.8 хувь 4-6 жил, 3.6 хувь нь 0-3 жилийн насжилттай байна.

Азотын давхар ислийн хамгийн их агууламж 2019 онд 0.058 мг/м^3 болж, өмнөх оноос 0.004 мг/м^3 (6.3%)-ээр буурсан ч хүлцэх агууламжаас 1.5 дахин их байна.

Агаар дахь азотын давхар ислийн хамгийн их болон дундаж агууламж 2020 оны эхний 3 сарын дунджаар $0.055\text{-}0.076 \text{ мг/м}^3$ болж, өмнөх оноос 11.1-19.7 хувиар нэмэгджээ.

Азотын давхар ислийн агууламжийн хүлцэх хэмжээнээс давсан хувийг сүүлийн 9 жилийн байдлаар харвал 2011 онд жилийн 365 хоногийн 55.8 хувь буюу 204 өдөр байсан бол үүнээс хойш буурсаар 2019 онд 25.5 хувь буюу жилийн 365 хоногийн 93 өдөр болж, өмнөх оноос 4.0 пункт буюу 15 өдрөөр буурчээ.

Азотын давхар ислийн хамгийн их агууламжийг сүүлийн 10 жилийн байдлаар харахад 2013 онд 0.093 мг/м³ болж, хамгийн их буюу хүлцэх агууламжаас 2.3 дахин байсан бол үүнээс хойш 2014-2017 онд буурч, дунджаар 0.064 мг/м³ болж, хүлцэх агууламжаас 1.6 дахин их болжээ. 2019 онд энэ үзүүлэлт 0.058 мг/м³ болж, өмнөх оноос 0.004 мг/м³ (6.3%)-ээр буурсан ч хүлцэх агууламжаас 1.5 дахин их байна.

Хүхэрлэг хийн хамгийн их болон дундаж агууламж 2020 оны эхний 3 сарын дунджаар 0.073-0.127 мг/м³ болж, өмнөх оноос 43.5-57.4 хувиар тус тус өссөн байна.

Хүхэрлэг хийн дундаж агууламжийн хүлцэх хэмжээнээс давсан хувийг сүүлийн 9 жилийн байдлаар харвал 2015 онд жилийн 365 хоногийн 55.6 хувь буюу 203 өдөр нь хүлцэх хэмжээнээс давсан бол, үүнээс хойш буурсаар 2018 онд 17.3 хувь буюу 63 өдөр, 2019 онд 23.0 хувь буюу 84 өдөр болж, өмнөх оноос 5.7 пункт буюу 21 өдрөөр нэмэгдсэн байна.

Агаарын бохирдол нь хүний биеийн амьсгалын тогтолцоо, зүрх судас, мэдрэл, нөхөн үржихүйн тогтолцооны зэрэг бүхий л эрхтэн тогтолцоо ялангуяа жирэмсэн эхийн ураг, 5 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй байна.

Сүүлийн таван жилийн дунджаар амьсгалын тогтолцооны өвчний түвшин (10000 хүн амд ногдох) 11-ээс дараа оны 1 дүгээр сар хүртэл хамгийн их байгаа нь 7, 8 дугаар сарын дунджаас 3.7 дахин их байна. Ялангуяа 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөл бусад насны хүн амын өвчлөлөөс 15.0-21.0 дахин их байна.

Улаанбаатар хотод 2019 онд амьсгалын тогтолцооны өвчний түвшин 1961 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 1.3 дахин, өмнөх оноос 373-аар, 5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын тогтолцооны өвчний түвшин (10000 хүүхдэд ногдох) 2019 онд 6405 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 699-өөр, өмнөх оноос 593-аар тус тус нэмэгджээ.

Улаанбаатар хотод 2019 оны байдлаар хатгалгаа өвчнөөр нас барсан 5 хүн тутмын нэг нь 5 хүртэлх насны хүүхэд байгаа нь өмнөх онтой адил байна.

Улаанбаатар хотын 0-17 насны хүүхдүүдийн амьсгалын тогтолцооны өвчний тохиолдлын эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн эмчилгээний зардал 2019 онд нийт 4989.0 сая төгрөг болж өмнөх оноос 436.2 сая (9.6%) төгрөгөөр нэмэгджээ. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн эмчилгээний зардал 2020 оны эхний 3 сарын дунджаар 4.7 сая төгрөг болж, өмнөх оноос 1.4 сая төгрөгөөр нэмэгджээ.

Агаарын бохирдолтой холбогдох нөхөн үржихүйн тогтолцооны өвчлөлийг сүүлийн 5 жилийн байдлаар харвал, 1000 амьд төрөлтөд ногдох дутуу төрөлт 2019 онд 72 болж, өмнөх оноос 9-өөр буурчээ. 1000 амьд төрөлтөд ногдох төрөлхийн гажигтай хүүхэд 2019 онд 8 болж, өмнөх оноос 2-оор нэмэгджээ. Харин амьгүй төрөлтийн түвшин 2019 онд 6 болж, өмнөх онтой адил түвшинд байна.

Өсөлтгүй жирэмслэлтийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох) 2019 онд 76 болж, улсын дунджаас 17-гоор, өмнөх оноос 7-гоор тус тус их байна.

Нөхөн үржихүйн тогтолцооны өвчлөлийг 2020 оны эхний 3 сарын дунджаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлхийн гажигтай төрсөн хүүхэд (1000 амьд төрөлтөд ногдох) 9 болж, адил түвшинд, амьгүй төрөлтийн түвшин 6 болж, 1-ээр буурч, 1000 амьд төрөлтөд ногдох дутуу төрөлт 76 болж 11-ээр нэмэгдсэн байна.

Зүрх, судасны тогтолцооны өвчлөлийн нэг болох 10000 хүн амд ногдох анхдагч даралт ихсэх өвчин 2019 онд 433 болж, 10 жилийн дунджаас 1.3 дахин, өмнөх оноос 1.2 дахин, зүрхний шигдээс өвчин 2019 онд 265 болж, 10 жилийн дундаж болон өмнөх оноос тус бүр 1.2 дахин өссөн байна.

Зүрх судасны тогтолцооны өвчлөл Улаанбаатар хотын хувьд агаарын бохирдол хамгийн өндөр саруудын дараагийн сард өндөр байгаа нь ажиглагдлаа.

Улаанбаатар хотод 2019 оны 5-р сараас сайжруулсан нүүрс хэрэглэж эхэлсэн болон манай улсад ковид-19 өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрөөс цэцэрлэг, сургууль, үйлчилгээний газруудын үйл ажиллагааг зогсоож, хөл хорио тогтоосон, хүн бүр амны хаалт зүүхийг шаардаж, хувийн болон амьдарч, ажиллах орчны ариун цэврийг эрс сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлснээр хүн амын зарим өвчлөлийн тохиолдол буурч байна.

Улаанбаатар хотын амбулаторид бүртгэгдсэн нийт өвчлөлийн тохиолдлын түвшин сүүлийн 5 жилийн эхний 3 сарын дунджаар харвал 2019 онд 1041 болж, хамгийн их байсан бол 2020 оны дунджаар 963 болж, 78-аар буурчээ.

Амьсгалын тогтолцооны өвчний түвшин 2016 онд 202 болж хамгийн их байсан бол 2020 оны эхний 3 сарын дунджаар 144 болж, өмнөх оноос 22-оор буурсан байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлтөөр олгодог амьсгалын замын үйл ажиллагаанд нөлөөлөх эмийн борлуулалт 2020 оны эхний 3 сарын дунджаар 7.3 сая төгрөг болж, өмнөх оноос 7.4 сая төгрөг (2 дахин)-өөр буурсан байна.

Өсөлтгүй жирэмслэлтийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох) сүүлийн 5 жилийн эхний 3 сарын байдлаар харвал 2017 онд дунджаар 90 болж, хамгийн өндөр байсан бол 2020 онд 79 болж, өмнөх оноос 7-гоор буурчээ.

Анхдагч даралт ихсэх өвчлөлийн түвшинг сүүлийн 5 жилийн эхний 3 сарын дунджаар харвал 2017 онд 43 болж, хамгийн их байсан бол 2020 онд 30 болж, өмнөх оноос 10-аар буурсан байна.

Цаашид энэ хүрсэн үр дүнг улам сайжруулж, агаарын бохирдлыг дараах чиглэлээр үйл ажиллагааг эрчимжүүлэх нь зайлшгүй болж байна. Тухайлбал:

- Агаарын бохирдолтой холбоотой нарийвчилсан судалгаа шинжилгээг нэгдсэн аргачлалын дагуу хийж, бодлого, хөтөлбөрт ашиглах;
- Агаарын чанарыг хянахад зайлшгүй шаардлагатай хэмжилтийн төхөөрөмжийг боловсронгуй болгон сайжруулан, шинэчлэх;
- Амьсгалын тогтолцооны өвчний түвшин сүүлийн 3 жилийн байдлаар аймгийн төвийн хувьд улсын дунджаас их болсон тул эхний ээлжид агаарын бохирдол ихтэй аймгуудад хэмжилтийн төхөөрөмжийг суурилуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах;
- Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжиж буй бодлого, хөтөлбөр, төсөл, үйл ажиллагааг нэгдсэн удирдлагад оруулж, үйл ажиллагааны үр дүнг тайлагнах, хянах, үнэлэх, хариуцлага тооцох тогтолцоог тодорхой болгох;

- Улаанбаатар хотын хүн амын төвлөрлийг сааруулах зорилгоор хэрэгжиж буй бодлого хөтөлбөрийг сайжруулан, хэрэгжилтийг хангахад анхаарах;
- Агаарын болон орчны бохирдлыг багасгах чиглэлээр хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлж, сум, дүүрэг, аймаг, хотын гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг шинэчлэх, цэвэр усыг түгээх, бохирыг татан зайлуулах инженерийн шийдлийг төлөвлөж хэрэгжүүлэх;
- Гэр хороололд амьдарч буй өрхүүдэд ариун цэврийн байгууламжтай болох, орон сууцны нөхцлөө сайжруулахад зориулж олон жилийн хүүгүй зээл олгох;
- Агаарын бохирдол ихтэй суурин газар болох аймаг, дүүрэг, сумын өрхийн хэрэглээнд сайжруулсан түлш хэрэглэх ажлыг үе шаттай зохион байгуулах;
- Агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагааны зардлын тооцоог холбогдох судалгаа, шинжилгээний ажилд тулгуурлан боловсруулах, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой болгох, зарцуулалтын явцад байнгын хяналт тавьж, ил тод мэдээлж байх;
- Эм ханган нийлүүлэх нэгдсэн тогтолцоог бэхжүүлж, чанартай эм тариаг хямд өртгөөр ханган нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;
- Ялангуяа эмзэг бүлгийн болон агаарын бохирдол ихтэй орчинд амьдарч буй өрхийн хүүхдүүд дунд амьсгалын замын цочмог үрэвсэл, уушгины архаг өвчлөлийг эмчлэх сайн чанартай эмийг үнэ төлбөргүй эсвэл хямд үнээр хүргэх боломжийг судалж, хэрэгжүүлэх.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монгол Улсын засгийн газар, Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр, 2017 он
2. Стандартчилал хэмжилзүйн газар, Агаарын чанар, Техникийн ерөнхий шаардлага-Монгол Улсын стандарт MNS 4585:2016, 2016 он
3. Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Баримтын цомог: Агаарын бохирдол хүний эрүүл мэндэд, 2018 он
4. Зориг сан, Агаарын бохирдлын тухай товчхон, 2017 он
5. НҮБ-ын Хүүхдийн сан, Хүүхдийн эрүүл мэндэд агаарын бохирдлын үзүүлэх нөлөө, шийдвэрлэх арга зам, 2016 он, Монгол Улс
6. ЭМШУИС, Хот суурин газрын агаарын бохирдлын хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн судалгаа, 2014 он
7. Дэлхийн банк, Улаанбаатар хотын агаарын бохирдол, 2009 он, Монгол Улс
8. НҮБ-ын, Хүүхдийн сан, Аюулын харанга: Агаарын бохирдол ба хүүхдийн эрүүл мэнд, 2018 он, Монгол Улс
9. Л.Дэлгэрзул, Улаанбаатар хотын агаарын бохирдол хүний эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөлөл, 2017 он
10. ДЭМБ, Монгол улсын агаарын бохирдол: Бодлогын товч, 2017 он
11. ДЭМБ, Гадаад орчны агаарын бохирдол: Эрүүл мэндэд үзүүлэх нөлөө <https://www.who.int/airpollution/ambient/health-impacts/en/>
12. "Нийслэл Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах мастер төлөвлөгөөний суурь судалгаа" боть, 2018 он
13. Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2018 оны 02 дугаар тогтоолын дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан
14. Статистикийн мэдээллийн сан- www.1212.mn
15. Эрүүл мэндийн яамны захиргааны тоо, мэдээлэл, 2010-2019 он